



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025.09.01 № 3Г-1/100
танай _____-ны № _____-т

Асуудал зөвшилцөх тухай

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 54 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР


000254004216

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“8.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2025 оны 08 дугаар сарын 18-ны өдөр
МОНГОЛ УЛС
БОЛОН
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (АХБ)
ХООРОНДЫН
САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР

ҮҮНЭЭС

(А) Монгол Улс Хавсралт 1-т туссан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор АХБ-аас зээлийн санхүүжилт хүсэж болно.

(Б) Монгол Улс болон АХБ Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр ("Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр") байгуулах хүсэлтэй байгаа ба энэ хүрээнд Монгол Улс нь АХБ-ны зээлийн нөхцөлийн дагуу АХБ-аас зээлийн санхүүжилт хүсэж болно.

ИЙМЭЭС талууд дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэсэг 1.01. Дор дурдсан Хэсэг 1.02 болон 1.03-т заасантай холбоотойгоор энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн Хавсралт 1-т заасан Монгол Улсын хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор АХБ нь Монгол Улсад зээлийн санхүүжилт олгож болно.

а) Зээлийн санхүүжилтийн хэмжээ нь дөрвөн зуун далан таван сая (475,000,000)¹ ам.доллараас хэтрэхгүй байх ба үүнийг АХБ-ны энгийн эх үүсвэрийн сангийн энгийн болон хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно.

Хэсэг 1.02. Хөгжлийн төсөл эсхүл хөтөлбөр тус бүрийн санхүүжилтийн хэмжээг Монгол Улс, АХБ-тай харилцан тохиролцож байгуулах зээлийн хэлэлцээрийн хүрээнд тохирно. Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн урьдчилсан мэдээллийг Хавсралт 1-т заасан болно. Түншлэлийн хөрөнгө оруулалтаар Монгол Улс өөрийн нутаг дэвсгэрт ногдуулж буй нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн албан татвараас чөлөөлөх мөн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зардлыг холбогдох Улсын төсвөөс санхүүжүүлснийг тооцно. Монгол Улсын нутаг дэвсгэрт ногдуулж буй нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн албан татвараас чөлөөлсөн тохиолдолд уг татварын чөлөөлөлтийг хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдэд оруулсан Монгол Улсын хөрөнгө оруулалт гэж үзнэ.

Хэсэг 1.03 Хөгжлийн төсөл, хөтөлбөр тус бүрийн зээлийн санхүүжилтийг Монгол Улсын хүсэлтийн дагуу болон АХБ-ны Захирлуудын зөвлөлөөр батлагдсаны үндсэн дээр АХБ-аас олгоно. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс нь зээл хүсэх, эсхүл АХБ нь зээл олгох үүрэг хүлээхгүй болно.

¹ Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн 1.01(а)-д заасан нийт зээл олгох хэмжээ/хязгаарт олон үе шатлалт санхүүжилт болон түүний үе шат бүрийн санхүүжилтийн хэмжээг хамруулахгүй болно.

Гарын үсэг /Signature/ *Мара*

20 25 оны 8 сарын 25 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хэсэг 2.01. АХБ-ны энгийн эх үүсвэрээс олгох энгийн зээлийн нөхцөл нь (а) 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан АХБ-ны Энгийн эх үүсвэрээс олгож буй энгийн нөхцөлтэй зээлд хамаарах АХБ-ны Энгийн үйл ажиллагааны зээлийн журмын заалтууд, (б) АХБ-ны санхүүжилтийн бодлогууд, (в) холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд захирагдана.

Хэсэг 2.02. АХБ-ны энгийн эх үүсвэрээс олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөл нь (а) 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан АХБ-ны Энгийн эх үүсвэрээс санхүүжих хөнгөлөлттэй зээлд хамаарах АХБ-ны Энгийн үйл ажиллагаа (хөнгөлөлттэй)-ны зээлийн журмын заалтууд, (б) АХБ-ны санхүүжилтийн бодлогууд, (в) холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд захирагдана.

Хэсэг 2.03. Монгол Улс нь АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөгжлийн төсөл эсхүл хөтөлбөрийг АХБ-ны авлигын эсрэг арга хэмжээ, хамгаалал, жендер, худалдан авалт, зөвлөх үйлчилгээ болон зээлийн ашиглалтын бодлогууд мөн холбогдох зээлийн хэлэлцээр болон бусад зээлийн баримт бичигт заасанд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Хэсэг 3.01. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг талуудын ил тод байдлын болон/эсхүл мэдээлэл тархаах тухай бодлогын дагуу олон нийтэд ил тод болгож болно.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэсэг 4.01. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурал соёрхон баталснаар хүчин төгөлдөр болох ба 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл эсхүл Хавсралт 1-т туссан төсөл, хөтөлбөр хэрэгжиж дуусах хүртэл аль сүүлд тохиох өдөр хүртэл хүчин төгөлдөр байна. Энэхүү хөтөлбөрийг талууд бичгээр тохиролцсоны дагуу сунгаж болно. Талуудын аль нэг Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг нөгөө талтайгаа зөвшилцсөний үндсэн дээр хүчингүй болгож болно.

- Заалтуудын төгсгөл -

Монгол Улс, Азийн Хөгжлийн Банк хооронд тохиролцсон дээрх заалтуудыг энд хөрвүүлсэн болно.


Хөтөлбөрийгоны ... дугаар сарын-ны өдөр Англи хэл дээр 2 хувь байгуулсан ба эх бичвэр бүр ижил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫГ төлөөлж

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКИЙГ төлөөлж

[Жавхлан Болд]
Сангийн сайд

[Шаннон Ковлин]
Монгол Улсад суугаа Суурин төлөөлөгч



Төсөл, Хөтөлбөрүүдийн жагсаалт

No.	Төслийн нэр	Нийт санхүүжилт (сая \$)
1	Аймгуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл	225.0
2	Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төсөл - 2 дахь үе нэмэлт санхүүжилт	130.0
3	Монгол Улсын ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлэх	20.0
4	Монгол Улсын гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл	100.0
	Нийт дүн	475.0

Монгол Улсын Сангийн яам
АЛБАН ЕСНЬ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ *марс*

20 *25* оны 8 сарын *25* өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

18 August 2024

**FINANCIAL FRAMEWORK ARRANGEMENT
BETWEEN
ASIAN DEVELOPMENT BANK (ADB)
AND
MONGOLIA**

WHEREAS

(A) Mongolia may from time to time request ADB to provide lending to finance its development projects and programs listed in Annex.

(B) Mongolia and ADB wish to establish a financial framework arrangement ("Framework Arrangement") within which Mongolia may request for lending from ADB and the terms and conditions for ADB to provide such lending.

NOW THEREFORE the parties hereto agree as follows:

ARTICLE I

Section 1.01. Subject to the provisions set out in Sections 1.02 and 1.03 below, ADB may provide lending to Mongolia to finance its development projects and programs as mentioned in Annex 1 to this Framework Arrangement.

a) The lending amount shall not exceed the equivalent of four hundred seventy five million dollars (\$475,000,000)¹, which may be used as regular and concessional loans from ADB's ordinary capital resources.

Section 1.02. The amount to finance each development project or program shall be as agreed upon in the signed loan agreement between ADB and Mongolia. The indicative details of the development projects and programs are set out in Annex 1 hereto. As counterpart investment, Mongolia may exempt the value added taxes and the custom duties imposed within the territory of Mongolia along with financing of project implementation units from the corresponding State Budget. Mongolia's exemption, if any, of applicable value added taxes and the customs duties imposed within the territory of Mongolia shall be treated as its counterpart investment in development projects and programs.

Section 1.03. For each development project or program, ADB shall provide lending only in response to a request by Mongolia and after approval by ADB's Board of Directors. This Framework Arrangement does not constitute an obligation on the part of Mongolia to request or on the part of ADB to approve any lending.

¹ The overall lending amount/ceiling specified in Section 1.01(a) of this Framework Arrangement does not include the indicative amounts specified for the multitranches financing facilities and their individual tranches.

ARTICLE II

Section 2.01. The terms and conditions of ADB lending using regular loans from ordinary capital resources shall be governed by (a) the provisions of ADB's Ordinary Operations Loan Regulations Applicable to Regular Loans Made from ADB's Ordinary Capital Resources, dated 1 January 2022; (b) ADB's financing policies; and (c) the relevant loan agreement.

Section 2.02. The terms and conditions of ADB lending using concessional loans from ordinary capital resources shall be governed by (a) the provisions of ADB's Ordinary Operations (Concessional) Loan Regulations Applicable to Concessional Loans Made from ADB's Ordinary Capital Resources, dated 1 January 2022; (b) ADB's financing policies; and (c) the relevant loan agreement.

Section 2.03. Mongolia shall implement the development project or program to be financed through ADB lending in accordance with all applicable ADB policies including those concerning anticorruption measures, safeguards, gender, procurement, consulting services, and disbursement to be described in detail in the relevant loan agreement and other loan documents.

ARTICLE III

Section 3.01 This Framework Arrangement may be publicly disclosed by each of the parties in accordance with their respective policies on disclosure and/or access to information.

ARTICLE IV

Section 4.01. This Framework Arrangement will come into effect on the date of ratification by the Parliament of Mongolia and will remain in effect until 31 December 2027, or the completion date of the projects and programs listed in Annex 1, whichever is the later. It may be extended for a further period as may be decided in writing by the Parties. Either Party may terminate this Framework Arrangement in consultation with the other Party.

--End of Clauses --

The foregoing record represents the understandings reached between Mongolia and Asian Development Bank upon the matters referred to therein.

Signed in duplicate in Ulaanbaatar, Mongolia, dated _____ each in the English language, all texts being equally authentic.

For
MONGOLIA

For
ASIAN DEVELOPMENT BANK

[Javkhlan Bold]
Minister
Ministry of Finance

[Shannon Cowlin]
Country Director
Mongolia Resident Mission

List of Indicative Projects and Programs

No.	Name of Project	Project cost (\$ million)
1	Provincial Health Service Strengthening and Modernization Project	225.0
2	Sustaining Access to and Quality of Education During Economic Difficulties Project – Second Additional Financing	130.0
3	Developing the skills and capacity of Mongolia's Workforce	20.0
4	Strengthening Mongolia's disaster resilience capacity project	100.0
	Total	475.0

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк
хооронд байгуулах “Санхүүжилтийн
ерөнхий хөтөлбөр”-ийн тухай

1. “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр” байгуулах шаардлага

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад “гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ”-г заавал Монгол Улсын Их Хурал соёрхон батлахаар заасны дагуу Засгийн газрын гадаад зээлийн хэлэлцээрүүдийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулдаг.

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэх, эрүүл мэндийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх, гамшгаас сэргийлэх үндэсний болон орон нутгийн чадавхыг бэхжүүлж, гамшигт тэсвэртэй дэд бүтцийг бий болгох зорилтуудын хүрээнд 4 төслийг тодорхойлж, Азийн хөгжлийн банк (цаашид “АХБ” гэх)-ны санхүүжилтийг баталгаажуулахаар “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг хамтран боловсруулаад байна.

“Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-т багтсан төслүүдийн хүрээнд АХБ-аас нийт 475.0 сая ам.долларын эх үүсвэрийг хуваарилж байгаа бөгөөд үүнээс 243.8 сая ам.долларын зээлийн эх үүсвэр нь хөнгөлөлттэй эх үүсвэр байна.

АХБ-ны хөнгөлөлттэй эх үүсвэр нь тогтмол 2 хувийн хүүтэй, 25 жилийн хугацаатай, эхний 5 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй. Харин энгийн нөхцөлтэй эх үүсвэр нь хөвөгч СОФР¹ хүү дээр 0.75 хувийн нэмэгдэлтэй, 0.15 хувийн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэлтэй бөгөөд 25 жилийн хугацаатай үүнээс үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа нь 5 жилтэй тэнцэж байна.

Цаашлаад “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулснаар Монгол Улс хөтөлбөрийн эх үүсвэрийг заавал авч ашиглах, зээл хүсэх үүрэг хүлээхгүй бөгөөд энэ нь зээлийн гэрээ биш юм. Харин хөтөлбөрийг Улсын Их Хурлаар соёрхон баталсан тохиолдолд АХБ-ны зүгээс санхүүжилтийн эх үүсвэрийг манай улсад хадгалж, “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн хавсралтад заасан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зээлийн хэлэлцээрийг байгуулж ажиллах боломжтой.

2. “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн тухай

“Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

¹ Secured Overnight Financing Rate /SOFR/

№	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэх шаардлага	Төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ	Зээлийн дүн (сая ам.доллар)
1	Аймгуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл	Монгол Улсын нийт нас баралтын 68% нь эмнэлгийн орчноос гадуур тохиолдож байгаа бөгөөд энэхүү нас баралтын түвшин нь хөдөө орон нутагт 79% байгаа нь олон улсын жишгээс хамаагүй өндөр байгаагаар холбоотойгоор орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг яаралтай хүртээмжтэй болгох шаардлага үүсээд байна.	Төслийн зорилго нь улсын хэмжээнд яаралтай болон эрчимт эмчилгээний дэд бүтцийг өргөжүүлэн шинэчлэх, түргэн тусламжийн автомашиныг сайжруулах, стандартчилсан протокол нэвтрүүлэх замаар таван жилийн хугацаанд урьдчилан сэргийлэх боломжтой нас баралтыг бууруулахад оршино. Төслийг амжилттай хэрэгжүүлснээр хот, хөдөөгийн ялгааг арилгаж, Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ. Энэ хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд: 1. Аймгийн 17 нэгдсэн эмнэлгүүдэд яаралтай тусламж болон эрчимт эмчилгээний тасаг, мөн мэс заслын өрөөний барилга, өргөтгөл болон шинэчлэл хийх; 2. Хөдөөгийн нэгдсэн 6 эмнэлэг болон төв зам, хилийн боомтын ойролцоо байрлах зарим сумын эрүүл мэндийн төвүүдийг үр ашигтай дэд бүтэц, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж яаралтай тусламжийн үйлчилгээг сайжруулна, 3. Тоног төхөөрөмжөөр тоноглогдсон түргэн тусламжийн автомашин, явуулын эмнэлгээр хангаж, одоо ашиглагдаж буй шинэчилнэ, 4. Хавдрын эрт илрүүлэг болон эрчимт эмчилгээний тасгуудыг сайжруулахын зэрэгцээ хими эмчилгээ, туяа эмчилгээ, дархлаа эмчилгээ болон бай эмчилгээний аргуудыг нэвтрүүлнэ, 5. Улсын хэмжээнд яаралтай тусламжийн протокол болон эрчимт эмчилгээний үйлчилгээний стандартыг тогтооно.	225.0
2	Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төсөл - 2 дахь нэмэлт санхүүжилт	Статистик тооцооллоор ирэх онуудад хүүхдийн тоо 2030 он хүртэл 14.4 хувиар өсөж, 88 мянга орчмоор нэмэгдэх төлөвтэй байна. Үүний улмаас нийт сургуулийн гуравны хоёр нь 2 болон түүнээс дээш ээлжээр хичээллэх эрсдэл бий. Иймд 2026 оноос эхлэн тус хэрэгцээг хангах бэлтгэл ажлыг хийх шаардлагатай бөгөөд нийтдээ 108 сургууль, 95 цэцэрлэг шинээр барих хэрэгцээ байна.	Төслийн гол зорилго нь 2026 оноос эхлэн нийт 32 сургууль, 9 цэцэрлэг шинээр барьж, сургалтын анги дүүргэлтийг бууруулж, хүүхэд, залуучуудын суралцах орчны хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино. Ингэснээр хот, хөдөөгийн боловсролын ялгааг багасгах, ерөнхий боловсролын чанарыг сайжруулах боломж бүрдэнэ. Төслийн хүрээнд барилга угсралт, хөрөнгө оруулалтыг үе шаттай зохицуулснаар улсын төсвийн ачааллыг нэмэгдүүлэхгүйгээр боловсролын дэд бүтцийг бэхжүүлнэ.	130.0
3	Монгол Улсын ажиллах хүчний үр	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага болон дээд боловсролын чанарыг	Төсөл нь хөдөө аж ахуйн салбар дахь хүний нөөцийн үр чадварыг хөгжүүлж, ухаалаг технологи, инновацыг нэвтрүүлэх мэргэжлийн болон техникийн боловсролын төрөлжсөн жишиг	20.0

	чадварыг хөгжүүлэх төсөл	хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцүүлэх чиглэлд онцгой анхаарах шаардлагатай байна. Мөн эдийн засгийг солонгоруулан ажиллах хүчний ур чадварыг сайжруулах замаар ногоон болон дижитал шилжилтийн шинэ боломжуудыг ашиглах чадвартай ажиллах хүчийг бэлтгэх нэн шаардлага тулгараад байна.	сургалтын тогтолцоог хөгжүүлэх зорилготой бөгөөд дараах зорилтын дагуу хэрэгжүүлнэ. Үүнд: 1.Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн хөдөө аж ахуйн төрөлжсөн, жишиг сургуулийг байгуулах; 2.Хөдөө аж ахуйн ажиллах хүчнийг бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрт ухаалаг технологи, инновацыг тусгаж шинэчлэх, салбар дундын чадавхыг бэхжүүлэх.	
4	Монгол Улсын гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл	Монгол орны нутаг дэвсгэрт үер, зуд, салхи шуурга, ой, хээрийн түймэр зэрэг байгалийн аюулын давтамж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр нэмэгдэхээс гадна олон улсын хөл хориотой хүн, малын гоц халдварт өвчний шинэ төрлийн аюулууд тохиолдож улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Сүүлийн арван жилд тохиолдсон аюулт үзэгдэл, осол өмнөх 10 жилийн дунджаас 32 хувиар, нэн ялангуяа уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдлийн давтамж 2.9 дахин нэмэгдсэн тул эдгээр гамшгийг сөрөн тэсвэрлэх, сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай байна.	Онцгой байдлын байгууллагын гал түймэр, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг сайжруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлж, гамшгийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэхэд зорилгын хүрээнд дараах 3 зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд: 1.Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг үндэсний стандартын шаардлагад хүргэн нэмэгдүүлж, олон улсын стандартад нийцсэн техник хэрэгсэл нэвтрүүлж онцгой байдлын байгууллагын гал түймэртэй тэмцэх чадавхыг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. 2.Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд ашиглах техник хэрэгсэл, тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын шаардлагад хүргэн нэмэгдүүлж, онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааны чадавхыг сайжруулна. 3.Орон нутгийн удирдлага, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, иргэд, сайн дурын хэсгүүдийг сургаж бэлтгэн, шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангаж, олон нийтийн гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулна.	100.0

3.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байдал

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т зааснаар Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байхаар хуульчлагдсан. Эдийн засаг 2026-2028 оны хооронд харгалзан 5.7 хувь, 6.3 хувь, 6.5 хувиар тус тус өсөхөөр тооцоологдож байгаагаас гадна Монгол Улсын 2025 оны төсөв, 2026 оны төсвийн төсөл, 2026-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасны дагуу гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглах тохиолдолд нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд 44.5 хувь, 2026-2028 онуудад 43 орчим хувьтай байхаар тооцоологдсон. Ингэснээр дунд хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлага болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хязгаарыг хангахаар байна.

---oOo---

“АЙМГУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ, ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨСӨЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.2-т “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ” гэж зааж, тус зорилтыг хэрэгжүүлэх **I үе шат (2021-2030)** буюу “Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе”-д зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулж, хүн амын дундаж наслалтыг уртасгахаар зорин ажиллаж байна.

Монгол Улсын 21 аймагт үйл ажиллагаа явуулдаг аймгийн нэгдсэн эмнэлэг болон бүсийн оношилгоо, эмчилгээний төв (лавлагаа шатлалын эмнэлэг)-үүд нь дотор, мэс засал, гэмтэл, эх барих, эмэгтэйчүүд, хүүхэд, яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ гэх мэт мэргэжлийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр тухайн аймгийн иргэдэд үзүүлдэг.


Өрхийн болон сумын эрүүл мэндийн төвүүдийн дэд бүтэц, тоног төхөөрөмжийн дутагдалтай байдал, хүний нөөцийн хомсдол, санхүүжилт зэргээс шалтгаалан анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж муу байна.

Цаашлаад уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зуд, ган зэрэг эрс тэс үзэгдэл нэмэгдэх нь эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхэд хүндрэл үүсгэж, нэн ялангуяа хөдөө орон нутгийн болон нүүдэлчин иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.

Монгол Улсын хэмжээнд 2014-2024 оны байдлаар 10 нас баралт тутмын 7 нь эмнэлгийн бус нас баралт байсан бөгөөд энэ нь олон улсын дунджаас өндөр байна. 2024 онд нийт 18,113 хүн нас барсан бөгөөд үүний 12,330 хүн эмнэлгээс гадуур нас барсан нь нийт нас баралтын 68%-ыг эзэлж байна. Эмнэлгийн бус нас баралт Улаанбаатар хотод 62%-тай, хөдөө орон нутагт 79%-тай байсан байна.

Эмнэлгийн бус нас баралт өндөр орлоготой улс орнуудад 27%, их, дунд орлоготой улс орнуудад 56%, бага, дунд орлоготой улс орнуудад 59%, Монгол Улсад 71%-тай байна. Монгол Улсад эмнэлгийн бус нас баралт анхаарал татахуйц өндөр байгаа нь яаралтай тусламжийн үйлчилгээ хангалтгүй, цаг хугацаа алдалт ихтэй, зохицуулалт хангалтгүй байгааг харуулж байна. Нийт 21 аймгийн хэмжээнд эрчимтийн 142 ор ашиглаж байгаагаас насанд хүрэгчдийн-81, хүүхдийн-33, нярайн-28 тус тус байна.

Нас баралтын бүтэц 2024 он



Word bank, United Nations Population Division. World Population Prospects: 2025

Мөн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тоног төхөөрөмж буюу хяналтын монитор-140, дефибриллятор-78, амьсгалын аппарат-88, хүчилтөрөгч өтгөрүүлэгч-99, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат-51, тариурын автомат шахуурга-126, дуслын автомат шахуурга-113, ЭХО аппарат /зөөврийн/-35, цус, цусан бүтээгдэхүүн хадгалах зориулалтын хөргөгч-21, пульсоксиметр-144, даралтны аппарат-145, зөөврийн отсос-76, зөөврийн каталк-62, цусны хийн шинжилгээний аппарат-8 тус тус ашиглагдаж байна. Тасралтгүй бөөр орлуулах эмчилгээний аппарат (CRRT) 21 аймгийн хэмжээнд Төв аймаг Нэгдсэн эмнэлэг, Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 2 ширхэг ашиглагдаж байна. Үлдсэн аймгуудад аппарат огт байхгүй байна.

Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд туулах чадвар сайтай 110 түргэн тусламжийн автомашин нэн шаардлагатай байна.

Төслийн хүрээнд дээрх хэрэгцээ шаардлагын дагуу үе шаттайгаар яаралтай тусламжийн болон эрчимт эмчилгээний тасгуудыг засварлах, шинээр барих, эмнэлгийн дэвшилтэт тоног төхөөрөмж худалдан авах, хөдөө орон нутгийн түргэн тусламжийн автомашиныг шинэчлэх, яаралтай тусламжийн мэргэжилтнүүдийг үндэсний болон олон улсын стандартад нийцүүлэн чадавхжуулснаар 5 жилийн дотор урьдчилан сэргийлэх боломжтой нас баралтыг 26 хүртэлх хувиар бууруулах, яаралтай болон эрчимт эмчилгээний өндөр чанартай тусламж үйлчилгээг улсын хэмжээнд хүртээмжтэй болгохоор зорьж байна.

Хоёр. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал

Төсөл нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн доор дурдсан баримт бичигт заасантай нийцнэ:

-“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.2-т “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ” гэж;

-Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн Зорилт 2.2-т “Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ” гэж;

-Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.2.5-д “Орчин үеийн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний төвийг бий болгох, эм, эмнэлгийн хэрэгслийг тогтвортой хүргэх зорилгоор нөөцийн агуулах байгуулна” гэж, 2.3.2.2-т “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх тогтолцоог бэхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэж, 2.3.4-т “Эрүүл мэндийн салбарын хүний нөөц” гэж;

-Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний 2.1.1.5-д “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх” гэж тус тус заасантай нийцнэ.

Цаашид хэрэгжүүлэх барилга, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь салбарын дунд болон урт хугацааны зорилттой уялдан хэрэгжих бөгөөд төрийн бодлого, төсвийн дэмжлэгээс гадна төр, хувийн хэвшлийн оролцоог татан оролцуулах, олон улсын хөнгөлөлттэй зээл, тусламжийг үр ашигтай ашиглах чиглэлд онцгойлон анхаарч байна.

Гурав. Төсөвт өртөг

		Сая ам.доллар
Зардал		Дүн
А. Хөрөнгө оруулалтын зардал		
1. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, хөдөөгийн эмнэлгүүдийн шинэчлэл		135.0
2. Эмнэлгийн тоног төхөөрөмж		42.0
3. Яаралтай түргэн тусламжийн автомашин, явуулын эмнэлэг		10.5
4. Цахим эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах*		9.0
5. Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, сургалт**		4.0
6. Зөвлөх үйлчилгээ /Зураг төсөв, барилгын хяналт/*		5.0
Нийт зардал (А)		205.5
Б. Магадалшгүй зардал		19.5
Нийт зардал (А+В)		225.0

*Зайн оношилгоо буюу телемедициний цэгүүдийг шаардлагатай эрүүл мэндийн байгууллагуудад байгуулж, эмч, мэргэжилтнүүдийг сургах
**Орон нутгийн хэмжээнд 2024 оны байдлаар 27,654 эмч, мэргэжилтнүүд ажиллаж байгаа бөгөөд шаардлагатай эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад хамруулна.
***Аймаг, сумын эмнэлгүүдийн барилга, байгууламжийг өргөтгөх, шинэчлэхэд зураг төсөв хийлгэх зөвлөх үйлчилгээ болон барилга угсралт, засварын ажлын захиалагчийн хяналтын зардал.

Дөрөв. Төслийн хүрээнд хийгдэх ажил, үр дүн

Төслийн зорилго: Хөдөө орон нутгийн буюу аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн дэд бүтэц, тоног төхөөрөмжийг өргөтгөх, сайжруулах,

хавдрын эрт илрүүлэг, эрчимт эмчилгээний тасгуудыг сайжруулах, түргэн тусламжийн автомашин, явуулын эмнэлгээр хангах, эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнуудын чадавхыг сайжруулах замаар бүс нутгийн хэмжээнд иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй авах боломжийг бүрдүүлэх зорилготой.

Төсөл хэрэгжих хугацаа: 2026-2030 он.

Төсөл хэрэгжих байршил:

No.	Эрүүл мэндийн байгууллагууд
Аймгийн нэгдсэн эмнэлгүүд / Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүд	
1	Архангай аймгийн Нэгдсэн эмнэлэг
2	Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлэг
3	Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг
4	Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг
5	Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
6	Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг
7	Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлэг
8	Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг
9	Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг
10	Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг
11	Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг
12	Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
13	Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
14	Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг
15	Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлэг
16	Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг
17	Завхан аймгийн Нэгдсэн эмнэлэг
Орон нутгийн эмнэлгүүд	
1	Мандал сумын эмнэлэг, Сэлэнгэ аймаг
2	Хархорин сумын эмнэлэг, Өвөрхангай аймаг
3	Булган сумын эмнэлэг, Ховд аймаг
4	Бор-Өндөр сумын эмнэлэг, Хэнтий аймаг
5	Замын-Үүд сумын эмнэлэг, Дорноговь аймаг
6	Тосонцэнгэл сумын эмнэлэг, Завхан аймаг
Сумын эрүүл мэндийн төвүүд	
Осол их гардаг төв зам дагуух болон хилийн боомт орчмын сумдын сонгогдсон эмнэлгүүд	

Жич: Дархан-Уул, Ховд, Увс, Орхон аймгуудын эмнэлгүүд жагсаалтад ороогүй. Учир нь Ховд, Увс аймгуудын эмнэлгийг АХБ-ны санхүүжилтээр шинэчилж байгаа, Дархан-Уул аймгийн эмнэлэгт ЕСБХБ-ны санхүүжилтээр шинэчлэл хийгдэж байгаа, Орхон аймгийн Медипас эмнэлгийг Хавдар судлалын үндэсний төвд Засгийн газрын шийдвэрээр шилжүүлэхээр болсон.

Төслийн хүрээнд хүрэх үр дүн:

Яаралтай тусламжийн болон эрчимт эмчилгээний тасгуудыг засварлах, шинээр барих, эмнэлгийн дэвшилтэт тоног төхөөрөмж худалдан авах, хөдөө орон нутгийн түргэн тусламжийн машиныг шинэчлэх, яаралтай тусламжийн мэргэжилтнүүдийг үндэсний болон олон улсын стандартад нийцүүлэн чадавхжуулснаар 5 жилийн дотор урьдчилан сэргийлэх боломжтой нас баралтыг 26 хүртэлх хувиар бууруулна.

Яаралтай болон эрчимт эмчилгээний өндөр чанартай тусламж үйлчилгээг улсын хэмжээнд хүртээмжтэй болгоно.

Энэхүү төсөл нь бүх нийтийн эрүүл мэндийн хамралт буюу хүн бүр чанартай тусламж, үйлчилгээг хэрэгцээтэй үедээ, хаана амьдарч байгаагаас үл хамааран авах боломжийг бий болгож байгаа юм.

1.Бүс нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, тогтвортой байдал сайжирна. (i) 17 аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдийг шинэчилж, чадавхыг бэхжүүлнэ. Уур амьсгалд тэсвэртэй, эрчим хүчний хэмнэлттэй дэд бүтэц, дэвшилтэт тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангаж, яаралтай оношилгоо, эмчилгээний чадавхыг нэмэгдүүлнэ; (ii) Хөдөөгийн нэгдсэн 6 эмнэлэг болон төв зам, хилийн боомтын ойролцоо байрлах зарим сумын эрүүл мэндийн төвүүдийг үр ашигтай дэд бүтэц, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж яаралтай тусламжийн үйлчилгээг сайжруулна; (iii) Яаралтай оношилгоо, эмчилгээний нэгжүүдийг сайжруулахын тулд шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон түргэн тусламжийн автомашин, явуулын эмнэлгээр хангаж, одоо ашиглагдаж буйг шинэчилнэ; (iv) Хавдрын эрт илрүүлэг болон эрчимт эмчилгээний тасгуудыг сайжруулахын зэрэгцээ хими эмчилгээ, туяа эмчилгээ, дархлаа эмчилгээ болон бай эмчилгээний аргуудыг нэвтрүүлнэ.

2.Хөдөө орон нутагт эрүүл мэндийн болон яаралтай тусламжийн үйлчилгээний уялдаа холбоотой сүлжээг бүрдүүлнэ. (i) Аймгийн нэгдсэн эмнэлгийг сумын эрүүл мэндийн төвүүдтэй хамтран ажиллах гол төв болгон бэхжүүлж, уялдаа холбоотой эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхийг дэмжих; (ii) Аймгийн нэгдсэн эмнэлэг болон Сумын эрүүл мэндийн төв хооронд дижитал дэд бүтцийг бий болгож өвчтөн шилжүүлэх, хүний нөөцийн солилцоо болон сургалт явуулах (ялангуяа яаралтай тусламжийн чиглэлээр) боломжийг бүрдүүлэх, мөн тоноглогдсон түргэн тусламжийн автомашин болон явуулын эмнэлгийг дижитал шийдлээр хангах; (iii) Аймгийн нэгдсэн эмнэлэг болон Сумын эрүүл мэндийн төвийг найдвартай, бүрэн ажиллагаатай теле-медицин системээр тоноглоно.

3.Эрүүл мэндийн байгууллагуудын засаглал, чадавх, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжинэ. (i) Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн стратеги боловсруулахыг дэмжиж, үүнд эрүүл мэндийн ажиллах хүчний тогтвортой байдал, карьерын өсөлтийг дэмжих чиглэлийг тусгана; (ii) Эмнэлгийн удирдлагын сургалтыг боловсруулж, нутагшуулахад дэмжлэг үзүүлж, мөн улсын эмнэлгүүдийн удирдлагыг бие даасан засаглалын чиглэлээр сургана; (iii) Эрүүл мэндийн яамны яаралтай тусламжийн тогтолцоог бэхжүүлж, ган, үер, зуд зэрэг байгалийн гамшигтай холбоотой яаралтай тусламжийн журам боловсруулна; (iv) Эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд өвчтөн шилжүүлэх, лавлагаа тусламжийн журам, өвчний тандалт, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчин, эрт сэрэмжлүүлэх систем, яаралтай тусламж, мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээ, эмнэлгийн удирдлага зэрэг чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулна.


**“АЙМГУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ,
ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ,
ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ**

1.Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Монгол Улсад эмнэлгийн бус орчинд гарч буй нас баралтын түвшин өндөр байгаа тул үүнийг бууруулахын тулд яаралтай тусламж, эрчимт эмчилгээний чанарыг сайжруулах шаардлагатай. /График 1/

/График 1/


**Яаралтай тусламжийн санхүүжилт ба тохиолдол,
орон нутаг ба нийслэл 2024**



Орон нутаг болон Улаанбаатар хотын 10 мянган хүн амд ногдох яаралтай тусламжийн тоог харьцуулахад орон нутагт тус үзүүлэлт нь 53 хувиар бага буюу хүртээмжгүй байна мөн нэг хүнд ногдох яаралтай тусламжийн санхүүжилтийн дүн нь орон нутагт 48 хувиар бага байна. Харвалт, шигдээс, осол, гэмтэл, амьсгалын тогтолцооны өвчин, жирэмсэн ураг нярай, хоол боловсруулах зарим өвчнүүдийг оруулан тооцоход 2024 онд нийт 18,113 иргэн нас барснаас 6,615 нь эмэгтэй, 11,498 нь эрэгтэй байсан бөгөөд үүний 12,330 хүн эмнэлгээс гадуур нас барсан нь нийт нас баралтын 68%-ыг эзэлж байна. Эмнэлгийн бус нас баралт Улаанбаатар хотод 62%-тай, хөдөө орон нутагт 79%-тай байсан байна.

Эрүүл мэндийн даатгалын тариф нь яаралтай тусламжийн нарийн төвөгтэй байдал, зарцуулалтаас хамаарч өндөр болдог бөгөөд нийслэлд дунджаар өртөг өндөртэй тусламж үзүүлж байна. /График 2/

10 мянган хүн амд ногдох яаралтай тусламжийн тоо аймгаар, 2024



10 мянган хүн амд ногдох яаралтай тусламжийн тохиолдлын тоогоор Говьсүмбэр аймаг тэргүүлж байгаа бөгөөд улсын дунджаас 2 дахин их байна. Хөвсгөл болон Баян-Өлгий аймаг хамгийн бага байгаа бөгөөд аврах боломжтой эмнэлгийн бус нас баралтын тоогоор Хөвсгөл аймаг хамгийн их байна.


Эрүүл мэндийн даатгалын сангаас 2023 онд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд 1.6 их наяд төгрөг зарцуулсан бөгөөд 13.4 хувийг яаралтай тусламжид зарцуулсан байна. Хүн амын 50 хувь нь орон нутагт, 50 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байгаа хэдий ч яаралтай тусламжийн тохиолдол нь Улаанбаатар хотод илүү байна. Нийт түргэн тусламжийн 20 хувийг аймгийн нэгдсэн эмнэлэг, 19 хувийг сумын эрүүл мэндийн төв үзүүлж байгаа бол 60 хувийг Улаанбаатар хотын түргэн тусламжийн төв үзүүлж байна /Хүснэгт 1/. 10 мянган хүн амд ногдох түргэн тусламжийн тоогоор Говьсүмбэр болон Улаанбаатар тэргүүлж байгаа бол Баян-Өлгий хамгийн бага байна.

Type of Ambulance service	Number of patients	Quantity	Share of total quantity	Amount MNT/	Үзүүлсэн ЗМБ %			Нийслэлийн түргэн тусламжийн төв
					СЭМТ	АНЭ	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	
Less than 25 km	551,625	654,512	89.95%	34,329,618,028	12.72%	22.26%	0.07%	64.96%
Between 25-75 km	37,197	39,602	5.44%	4,292,066,565	74.50%	3.87%	0.48%	21.15%
Between 75-450 km	30,224	31,454	4.32%	17,970,645,024	89.09%	10.18%	0.17%	0.57%
Between 450-800 km	1,091	1,115	0.15%	1,022,306,618	0.00%	80.16%	2.78%	17.04%
Above 800 km	868	870	0.12%	1,587,398,165	0.11%	93.33%	6.55%	0.00%
Grand Total	621,005	727,553	100.00%	59,202,034,400	19.35%	20.91%	0.10%	59.63%


10 мянган хүн амд ногдох яаралтай тусламжийн тоо орон нутагт Улаанбаатар хотоос 53 хувиар бага буюу хүртээмжгүй байгаагаас гадна нэгж үйлчилгээнд ногдох санхүүжилтийн дүн нь орон нутаг 48 хувиар бага байна. Эрүүл мэндийн даатгалын тариф нь яаралтай тусламжийн нарийн төвөгтэй байдал, зарцуулалтаас хамаарч өндөр болдог бөгөөд нийслэлд дунджаас өртөг өндөртэй тусламж үзүүлж байна. 10 мянган хүн амд ногдох яаралтай тусламжийн тохиолдлын тоогоор Говьсүмбэр аймаг тэргүүлж байгаа бөгөөд улсын дунджаас 2 дахин их байна.

Мөн 10 мянган хүн амд ногдох эрчимт эмчилгээний тоо орон нутагт Улаанбаатар хотоос 2.2 дахин бага буюу хүртээмжгүй байна /График 3/. Нэгж үйлчилгээнд ногдох санхүүжилтийн дүн нь орон нутагт Улаанбаатар хотын дунджаас 2.1 дахин бага байна /График 4/. Эрүүл мэндийн даатгалын тариф нь эрчимт эмчилгээний чадавхаас хамаарч өндөр болдог бөгөөд нийслэлд нарийн мэргэжлийн эрчимт эмчилгээний тусламж үзүүлж байна. 10 мянган хүн амд ногдох эрчимт эмчилгээний тохиолдлын тоогоор Говьсүмбэр аймаг тэргүүлж байгаа бөгөөд улсын дунджаас 3 дахин их байна. Булган, Хөвсгөл, Баян-Өлгий аймгууд нь бусад аймгуудтай харьцуулахад бага байна.

/График 3/



10 мянган хүн амд ногдох эрчимт эмчилгээний тоо орон нутагт Улаанбаатар хотоос 2.2 дахин бага буюу хүртээмжгүй байна. Нэгж үйлчилгээнд ногдох санхүүжилтийн дүн нь орон нутагт Улаанбаатар хотын дунджаас 2.1 дахин бага байна.



10 мянган хүн амд ногдох эрчимт эмчилгээний тохиолдлын тоогоор Говьсүмбэр аймаг тэргүүлж байгаа бөгөөд улсын дунджаас 3 дахин их байгаа бол Булган, Хөвсгөл, Баян-Өлгий аймгууд нь бусад аймгуудтай харьцуулахад эрчимт эмчилгээний тохиолдлын тоогоор бага байна.

2.Төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүн, ач холбогдол

2.1.Аймаг, бүсийн эрүүл мэндийн үйлчилгээний чадавхыг сайжруулах чиглэлээр:

- 17 аймгийн нэгдсэн эмнэлэг болон бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг шинэчилж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах;
- Сумдын эрүүл мэндийн төвүүдийг уур амьсгалд тэсвэртэй дизайн, сурталчилгааны арга хэмжээгээр сайжруулах;
- Түргэн тусламжийн автомашин, явуулын эмнэлгийг шинэчлэх;
- Хавдрын оношилгоо, эмчилгээний төвүүдийг өргөтгөх.

2.2.Хөдөөгийн эрүүл мэнд, яаралтай тусламжийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр:

- Аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн удирдлага, зохион байгуулалт болон сумын эрүүл мэндийн төвүүдийн харилцаа холбоог сайжруулах;
- Телемедицин системийг нэвтрүүлж, түргэн тусламжийн автомашин, явуулын эмнэлгийг дижиталжуулах;
- Сүлжээний зохион байгуулалтын дагуу үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлэх.

2.3.Эрүүл мэндийн байгууллагын засаглал, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих чиглэлээр:

- Эрүүл мэндийн хүний нөөцийн стратеги боловсруулах;
- Нийтийн эмнэлгийн менежмент, бие даасан байдлыг дэмжих сургалт зохион байгуулах;
- Яаралтай тусламжийн системийг (EMS) гамшгийн үед ажиллах протоколтой болгох.

3.Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Аймгийн нэгдсэн эмнэлгийг алгасан нийслэлд эмчилгээ хийлгэж буй өвчтөнүүдийн мэдээлэлд хийсэн шинжилгээгээр замын зардал, байрлах зардал, цалингийн алдагдал зэрэгт иргэд хувиасаа их хэмжээний зардал гаргаж байна. Жил бүр 280,000 гаруй өвчтөн аймгийн эмнэлгийг алгасан, Улаанбаатар хотын төв эмнэлгүүдэд шууд амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тусламж авдаг. Эдгээр өвчтөнүүд дунджаар 1,000 км-ээс дээш зам туулж, аймгаасаа нийслэлд ирээд буцдаг. Шинжилгээ хийхдээ ихэнх өвчтөн автобус ашигладаг, харин Баян-Өлгий, Увс, Ховд зэрэг баруун бүсийн алсын зайн нислэгийн коридорт орших аймгуудаас нисэж ирж болдог байна.

Өвчтөнүүд нийтдээ 13.5 сая ам.долларын замын зардлыг хувиасаа гаргаж байна (дунджаар нэг өвчтөн 200,000 төгрөг). Энэ бол эмнэлгийн бус, зайлшгүй гарах зардал бөгөөд өвчтөн бүр аймгийн эмнэлгийг алгасан нийслэл рүү явах тохиолдол бүрд давтагдан гардаг тул өрхийн санхүүд тогтмол дарамт болдог.

Мөн санхүүгийн томоохон дарамтын нэг нь цалин/бүтээмжийн алдагдал юм. Өвчтөн аймгийн эмнэлгийг алгасан Улаанбаатарт үйлчилгээ авахдаа дунджаар хоёр өдөр зорчих тул өдөр тутмын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 110,000 төгрөгөөр тооцвол нийтдээ 18.8 сая ам.долларын алдагдал гарч байна. Ингэснээр аялал болон цалингийн алдагдлын нийлбэр өртөг нь 32.3 сая ам.долларт хүрч байгаа бөгөөд өвчтөн бүрийн хамт явах асран хамгаалагчийг тооцвол 64.5 сая ам.долларт хүрнэ.

Дээрх зардалд байрлах зардал, эмчилгээ авч чадаагүй тохиолдол, өвчтөний сэтгэлзүйн дарамт, төв эмнэлэг дэх хүлээлгийн хугацаа, эрүүл мэндийн тогтолцооны бусад үр ашиггүй байдлыг нэмбэл дарамт улам нэмэгдэх юм. Энэ хэмжээний зардал нь эрүүл мэндийн тусламж авахад санхүүгийн бодит саад болж байгааг харуулж байгаа бөгөөд үүнийг мэдээллийн нэгдсэн сүлжээний зохицуулалт, дахин зорчих явдлыг багасгах цагийн хуваарь, мөн алслагдсан чиглэлд зорилтот дэмжлэг үзүүлэх замаар бууруулах боломжтой.

Төслийн хүрээнд аймаг, бүсийн түвшинд эрүүл мэндийн үйлчилгээний чадавхыг бэхжүүлснээр улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулах юм. Түргэн тусламжийн үйлчилгээ, эрчимт эмчилгээ, зүрх судасны өвчин, осол гэмтлийн тусламжийг сайжруулах нь урьдчилан сэргийлэх боломжтой нас баралтын түвшнийг бууруулна.

Аймгийн нэгдсэн эмнэлгүүд дээр шаардлагатай лаборатори, оношилгооны тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон, замын нөхцөлд тохирсон явуулын эмнэлгүүдийг байгуулах нь алслагдсан хөдөө орон нутаг, нүүдэлчин малчдад эрүүл мэндийн

тусламжийг ойртуулах чухал шийдэл болно. Энэ нь өвчний эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээний хүртээмжийг мөн нэмэгдүүлнэ.

Түүнчлэн, орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдийг сургах, чадавхыг нь сайжруулах нь тэднийг ажлын байрандаа тогтвортой байлгахад дэмжлэг болно. Аймгийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулснаар лавлагаа тусламжийн тогтолцоог боловсронгуй болгож, иргэдийн зам, байрны хувийн зардлыг бууруулан өрхийн санхүүд үзүүлэх дарамтыг багасгана. Үүний зэрэгцээ аймгийн эмнэлгүүдийн санхүүгийн урсгал нэмэгдэж, эмч, сувилагчдын цалинг нэмэгдүүлэх, шинэчлэгдсэн барилга, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг тогтвортой ашиглах боломж бүрдэнэ.

---oOo---

“ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ - 2 ДАХЬ НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан Хүний хөгжлийн зорилтод 2030 он гэхэд тэгш боломж бүрдүүлсэн, хүртээмжтэй, чанартай, насан туршийн суралцахуйд суурилсан боловсролын тогтолцоог хөгжүүлэхээр зорьж ажиллаж байна. Энэ зорилтын хэрэгжилтийн үр дүнг монгол хүний хөгжлийн түвшинд гарсан ахицаар хэмждэг бөгөөд үүний нэг бүрэлдэхүүн шалгуур үзүүлэлт нь боловсролын индекс байдаг.

Боловсролын индекс нь боловсрол эзэмшсэн хүн амын эзлэх жин болон боловсролын чанарын үр дүнгийн харьцаагаар хэмжигддэг тул стандартын шаардлага хангасан орчин, нөхцөл бүхий сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хамран сургалт, түүний чанарыг сайжруулах нь тэргүүлэх ач холбогдолтой зорилт юм.

2024-2025 оны хичээлийн жилд 3-5 насны нийт хүүхдийн 94.1% сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж, улсын дундаж өссөн бөгөөд бага боловсролын (1-5-р анги) хамран сургалтын цэвэр жин 97.7%, дунд ангийн (6-9-р анги) хамран сургалтын цэвэр жин 96.0%, ахлах ангийнх 97.0%-тай байна.

Хэдийгээр хамран сургалт тогтмол өсөж байгаа ч 2050 он хүртэлх хүүхдийн тооны өсөлтийг, сургууль, цэцэрлэгийн багтаамжтай харьцуулан тооцож үзэхэд суудлын тоо, орны тоо дутагдахаар байна. 2050 он хүртэлх цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн тооны өсөлтийн урьдчилсан таамаглалаас харахад хүүхдийн тооны хамгийн оргил үе 2028-2030 онд тохиохоор байгаа бөгөөд сургууль, цэцэрлэгийн барилгыг барих хугацаа дунджаар 3-5 орчим жил байдаг гэж үзвэл энэ оргил үеийг давах бэлтгэл ажлыг одооноос хийхээс өөр аргагүй нөхцөл байдалтай байна.

Хүн амын статистик тооцооллоор 2030 он хүртэл хүүхдийн тоо 14.4 хувиар буюу 88 мянга орчмоор нэмэгдэх төлөвтэй байна. Нэмээд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 45 хувь буюу 317 сургууль нь 2 болон түүнээс дээш ээлжээр хичээллэж байгаа буюу нийт ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа хүүхдүүдийн 68 орчим хувь хоёр ээлжээр хичээллэж байна. Энэ нь хүүхэд хичээлээс гадуур авьяас, сонирхлоо хөгжүүлэх үйл ажиллагаа, дугуйлан, клубт хамрагдах боломжгүй болгож байна. 2022 онд хийгдсэн олон улсын ПИСА үнэлгээний үр дүнгийн шинжилгээгээр сургуулийн ээлжийн коэффициент/ачаалал/-г бууруулж, бага ээлжээр хичээллэх нөхцөл бүрдвэл сурагчид илүү тогтвортой цагийн хуваарьтай хичээллэх боломж бүрдэж, улмаар суралцах орчин сайжирснаар сурлагын чанар, ялангуяа математикийн амжилт дээшилж дунджаар 8 оноогоор нэмэгдэх нөхцөл бүрддэг нь тогтоогдсон.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Эрдэм боловсролтой Монгол хүн” зорилгыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2-17 насны хүүхдийн боловсролд хамрагдалтыг сайжруулах, сургуулиудыг нэг ээлжээр бууруулах, анги бүлгийн хүүхдийн тоог стандартын түвшинд хүргэхээр зорьж, 2028 он хүртэл 95 цэцэрлэг, 108 сургуулийг шинээр барихаар төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эдгээр сургууль, цэцэрлэгүүдийг 2028 он хүртэл үе шаттай барьснаар 12,240 орны хүчин чадалтай 95 цэцэрлэг, 80,400 суудлын хүчин чадал бүхий 108 сургуультай болно. Ингэснээр дунд хугацаандаа хүүхдийн хөгжил, хамгааллын үзүүлэлтүүд ахиж, багшийн ачаалал буурах бөгөөд үүний үр дүнд сургалтын чанарт эерэг үр дүн гарна гэсэн хүлээлттэй байна.

Боловсролын яамнаас Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах” төслийн нэгдүгээр бүрэлдэхүүний хүрээнд 2 сургууль, 2 цэцэрлэг шинээр барьж, 5 сургууль, 12 цэцэрлэгийн барилгыг өргөтгөснөөр сургуулийн суудлын тоог 3,400, цэцэрлэгийн орны тоог 2,325-аар тус тус нэмэгдүүлсэн бөгөөд төслийн 2-р шатны хүрээнд 41 барилга байгууламжийг барихаар төлөвлөн ажиллаж байна.

Хоёр. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.1-д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэж заасан.

Тус төсөл нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Боловсролын салбарын 2021-2030 оны дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд туссан (i) тэгш, хүртээмжтэй, амьдралд нийцсэн боловсролын үйлчилгээг үзүүлэх; (ii) хөдөө орон нутгийн хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах; (iii) ерөнхий боловсролын сургуулийн 3 ээлжээр хичээллэх асуудлыг шийдвэрлэн анги дүүргэлтийн хэт ачааллыг бууруулах; (iv) бүх шатны боловсролын үйлчилгээнд сургалтын чанар, үр дүнг үнэлэх үнэлгээний системийг бий болгох; (v) стандартад суурилсан боловсролын тогтолцоог бүрдүүлэх; (vi) боловсролын цахим шилжилт зэрэг үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, анги дүүргэлтийг бууруулах зорилтыг баталсан. Засгийн газар тус үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Эрдэм боловсролтой Монгол хүн” зорилгыг хэрэгжүүлэх, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласан. Энэ хүрээнд боловсролын салбарын дэд бүтцийг өргөтгөх, чанар, хүртээмжийг сайжруулах, олон ээлжийн сургалтыг бууруулах, хөдөө орон нутагт боловсролын ялгааг багасгах бодлого хэрэгжиж байна.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд 45 сургууль, цэцэрлэгийг тус тус шинээр барьж эхлүүлэхээр батлагдсан. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлснээр дунд хугацаанд нийтдээ 30,000 гаруй хүүхдийг шинээр сургууль, цэцэрлэгийн үйлчилгээнд хамруулах боломж бүрдэхээр байгаа бөгөөд энэ нь сургалтын орчин нөхцөлийг сайжруулж, олон ээлжийн сургалтын ачааллыг бууруулахад чухал дэмжлэг үзүүлнэ.

Цаашид 2026 оноос эхлэн хэрэгжүүлэх барилга, хөрөнгө оруулалтын ажлууд нь салбарын урт болон дунд хугацааны зорилттой уялдан хэрэгжих бөгөөд төрийн бодлого, төсвийн дэмжлэгээс гадна хувийн хэвшлийн оролцоог татан оролцуулах, олон улсын хөнгөлөлттэй зээл, тусламжийг үр ашигтай ашиглах чиглэлд онцгойлон анхаарч байна.

Гурав. Төслийн санхүүжилт, нөхцөл

Төслийн нийт өртөг урьдчилсан тооцоогоор 130.0 сая ам.доллар байна.

	Санхүүжүүлэх арга хэмжээ	Дүн
A	Хөрөнгө оруулалтын өртөг	
1	Цэцэрлэг, сургуулийн барилга угсралтын ажлын төсөв	110.3
2	Зөвлөх үйлчилгээ /Зураг төсөв, хяналт/	4.8
	Нийлбэр дүн (A)	115.1
B	Магадалшгүй зардал	14.9
	Төслийн нийт өртөг	130.0

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зардал, гааль болон импортын татварын чөлөөлөлтийг зардлыг Монгол Улсын Засгийн газраас санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Дөрөв. Төслийн хүрээнд хийгдэх ажил, үр дүн

Төслийн зорилго: Төсөл нь Монгол Улсын цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар 2-17 насны хүүхдүүдэд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чанартай үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг бүрдүүлнэ. Энэхүү зорилгыг дараах зорилтын дагуу хэрэгжүүлнэ. Үүнд:

1.Ерөнхий боловсролын 32 сургууль, 9 цэцэрлэгийн барилгыг ногоон, дижитал үзэл баримтлал бүхий стандарт, техникийн зохицуулалтын дагуу шинээр барьж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөртэй нийцүүлэн цахим сургалт, контентын санг шинэчлэн хөгжүүлж, сургалтад нэвтрүүлэх замаар сургалтын чанарыг сайжруулах.

Төсөл хэрэгжих хугацаа: 2026–2031 он

Төсөл хэрэгжих байршил: Төслийн хүрээнд Улаанбаатар хот болон орон нутагт нийт 41 сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

№	Аймаг, Нийслэл	Сум, Дүүрэг	Объектын төрөл	Хүчин чадал	Төсөвт өртөг /сая.төг/
1	Орхон	Баян-Өндөр	Сургууль	960	16,265.50
2	Өмнөговь	Цогтцэций	Сургууль	960	16,265.50
3	Улаанбаатар	Сонгинохайрхан	Сургууль	960	16,265.50
4	Улаанбаатар	Баянзүрх	Сургууль	960	16,265.50
5	Улаанбаатар	Сүхбаатар	Сургууль	960	16,265.50
6	Улаанбаатар	Баянгол	Сургууль	960	16,265.60
7	Хэнтий	Хэрлэн	Сургууль	960	16,265.60
8	Улаанбаатар	Баянзүрх	Сургууль	960	16,265.50
9	Улаанбаатар	Хан-Уул	Сургууль	960	16,265.50

10	Улаанбаатар	Сонгинохайрхан	Сургууль	640	12,728.30
11	Улаанбаатар	Баянзүрх	Сургууль	640	12,728.30
12	Дархан-Уул	Дархан	Сургууль	640	12,728.30
13	Өвөрхангай	Арвайхээр	Сургууль	640	12,728.30
14	Сэлэнгэ	Сүхбаатар	Сургууль	640	12,728.30
15	Улаанбаатар	Сонгинохайрхан	Сургууль	640	12,728.30
16	Улаанбаатар	Баянзүрх	Сургууль	640	12,728.30
17	Улаанбаатар	Хан-Уул	Сургууль	640	12,728.30
18	Улаанбаатар	Сүхбаатар	Сургууль	640	12,728.30
19	Улаанбаатар	Сүхбаатар	Сургууль	640	12,728.30
20	Говь-Алтай	Цогт	Сургууль	320	7,732.00
21	Дорнод	Хэрлэн	Сургууль	320	7,732.00
22	Дундговь	Сайнцагаан	Сургууль	320	7,732.00
23	Сүхбаатар	Баруун-Урт	Сургууль	320	7,732.00
24	Увс	Зүүнговь	Сургууль	320	7,732.00
25	Архангай	Өндөр-Улаан	Сургууль	320	7,732.00
26	Улаанбаатар	Хан-Уул	Сургууль	320	7,732.00
27	Улаанбаатар	Хан-Уул	Сургууль	320	7,732.00
28	Улаанбаатар	Баянгол	Сургууль	320	7,732.00
29	Улаанбаатар	Сонгинохайрхан	Сургууль	320	7,732.00
30	Хэнтий	Бор-Өндөр	Сургууль	320	7,732.00
31	Улаанбаатар	Налайх	Цэцэрлэг	150	4,641.10
32	Говьсүмбэр	Шивээговь	Сургууль	160	3,884.13
33	Төв	Баянцагаан	Сургууль	160	3,884.13
34	Архангай	Эрдэнэбулган	Цэцэрлэг	150	3,641.10
35	Дорноговь	Хатанбулаг	Цэцэрлэг	150	3,641.10
36	Завхан	Улиастай	Цэцэрлэг	150	3,641.10
37	Баян-Өлгий	Өлгий	Цэцэрлэг	100	2,903.00
38	Баянхонгор	Баянцагаан	Цэцэрлэг	100	2,903.00
39	Булган	Рашаант	Цэцэрлэг	100	2,903.00
40	Ховд	Булган	Цэцэрлэг	100	2,903.00
41	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	Цэцэрлэг	100	2,903.00
НИЙТ ДҮН					396,572.36

/Монгол банкны 2025 оны 08-р сарын 28-ний өдрийн ханшаар 1 ам.доллар=3594.42 төгрөгөөр тооцов./

Төслийн хүрээнд хүрэх үр дүн:

Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2028 онд дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

1.1.Нийт 9 цэцэрлэгийг орон нутгийн 8 байршил, нийслэлд 1-ийг тус тус барьснаар 1,100 хүүхэд стандартын шаардлага хангасан орчин, нөхцөлд сургуулийн өмнөх боловсролд хамрагдана;

1.2.Нийт 18,880 хүүхдийн хүчин чадал бүхий 32 сургуулийг орон нутгийн 15 байршил, нийслэлийн 5 дүүрэгт барьснаар 37,760 хүүхэд стандартын шаардлага хангасан орчин, нөхцөлд ерөнхий боловсролд хамрагдана.

2.Цахим сургалт, контентыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2029 онд дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

2.1.Сургуулийн өмнөх боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих цахим контентыг 25 багц сэдвийн хүрээнд хөгжүүлж, сургуулийн өмнөх боловсролын 250 орчим мянган хүүхдэд хүргэнэ;

2.2.Ерөнхий боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөртэй нийцүүлэн Мэдлэ цахим сангийн 10279 хичээлийг шинэчилсэн байна.


---oOo---

“ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ – 2 ДАХЬ НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ


1.Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын ерөнхий боловсролын сургалтын дэд бүтэц хот, хөдөөгийн хэмжээнд тэнцвэргүй хөгжсөн хэвээр байна. Улсын хэмжээнд нийт сургуулийн 45 хувь нь 2 болон түүнээс дээш ээлжээр хичээллэж байгаа нь анги дүүргэлтийг нэмэгдүүлж, зарим сургууль, цэцэрлэгийн хүчин чадал хүрэлцэхгүй нөхцөл байдалд хүргэж байна. Энэ нь хүүхэд, залуучуудын чанартай боловсрол эзэмших боломжийг хязгаарлаж, улмаар нийслэл болон орон нутгийн боловсролын ялгааг улам гүнзгийрүүлэх шалтгаан болж байна.

Улсын хэмжээнд 2308 боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 74.3% нь төрийн өмчийн 25.7% нь хувийн сургуулиуд байна. Байршлын хувьд нийслэлд 985, аймгийн төвд 507, сумын төвд 768 болон багийн төвд 48 байгаа бөгөөд нийт барилгын дундаж наслалт 24.8 жилтэй байна /Зураг 1/.



Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Эрдэм боловсролтой Монгол хүн” зорилгыг хэрэгжүүлэх, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх зорилгоор 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласан. Энэ хүрээнд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын нийт 1,702 байгууллагын ээлжийн коэффициентийг тооцож, дүн шинжилгээ хийсэн. Үүнээс 2 болон түүнээс дээш ээлжээр үйл ажиллагаа явуулж буй 652 боловсролын байгууллага байна /Зураг 2/.



Тооцооллоор 2030 он хүртэл ерөнхий боловсролын сурагчдын тоо 14.4 хувиар өсөж, 88,000 хүүхдээр нэмэгдэх төлөвтэй. Хэрэв шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлэхгүй бол сургуулиудын 45 хувь нь цаашид ч 2 болон түүнээс дээш ээлжээр хичээллэх эрсдэлтэй байна. Үүнийг бууруулахын тулд 2026 оноос эхлэн бэлтгэл ажлыг хангаж, боловсролын салбарын дэд бүтцийн шинэчлэлийг эрчимжүүлэх шаардлагатай.

Энэ зорилгоор 108 сургууль, 95 цэцэрлэг шинээр барих хэрэгцээ байгаагаас эхний ээлжид тус бүр 45 сургууль, цэцэрлэгийг тус тус барихаар Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгаад байна.

Хөдөө орон нутгаас хот руу, ялангуяа Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нь хот суурин газрын гэр хорооллыг улам тэлж, орлого багатай өрхийн тоог нэмэгдүүлж байна. Улаанбаатар хотын хүн амын 56 хувь нь гэр хороололд, тэр дундаа Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт оршин суудаг. Хүн амын хурдацтай өсөлтийг дагаад цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн тоо нэмэгдэж байна. Сургууль, цэцэрлэгийн хүчин чадал дээрх хүн амын өсөлтийн хурдыг нэн ялангуяа сургууль, цэцэрлэгийн насны хүүхдийн өсөлтийг хангаж чадахгүй түвшинд байгаа учир сургууль цэцэрлэгүүд ачааллаа даахгүйд хүрч, боловсролын чанар, тэгш, хүртээмжтэй байдалд сөргөөр нөлөөлж байна. Үүний зэрэгцээ алслагдсан бүс нутагт сургууль, цэцэрлэгийн барилгыг барьж, өргөтгөх нь тэгш хамруулан сургах бодлогыг дэмжих, хот, хөдөөгийн боловсролын тэгш бус байдлыг бууруулах ач холбогдолтой юм.

Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт улсын дунджаас их буюу 30-аас дээш, зарим тохиолдолд 40-50-д хүрдэг. Мөн Улаанбаатар хотод бүлэг дүүргэлтийн дундаж 33.1 байгаа нь орон нутгийнхаас 5.1 пунктээр өндөр байна.

Манай улсад 2022 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 0-18 насны 11,835 хүүхэд байна. Үүнээс хөдөлгөөний бэрхшээлтэй 2,422, харааны бэрхшээлтэй 1,087, хэл ярианы бэрхшээлтэй 825, сонсголын бэрхшээлтэй 644, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй 2,263, хавсарсан бэрхшээлтэй 1,152, бусад бэрхшээлтэй 3,342 хүүхэд байна. 2024-2025 оны хичээлийн жилийн эхэнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй 2,150 хүүхэд, ерөнхий боловсролын сургуульд 6,273 сурагч суралцаж байна.

Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургадаг тусгай 2 цэцэрлэг, 6 сургууль хичээл сургалтын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийт 1,993 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна. Энэ нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн зөвхөн 27.7 хувь болж байна. Өөрөөр хэлбэл 72.3 хувь нь ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг сонгон суралцаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ердөө 64 хувь нь сургуульд суралцаж байгаатай холбоотойгоор ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр барьж ашиглалтад оруулж буй сургууль, цэцэрлэгийн барилгууд нийгэм, жендерийн хэрэгцээ шаардлагыг хангах нь чухал асуудал болж байна.

2.Төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүн, ач холбогдол

“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл - 2 дахь нэмэлт санхүүжилт” нь ногоон, дижитал үзэл баримтлал бүхий стандарт, техникийн зохицуулалтын дагуу сургууль, цэцэрлэгийг шинээр барьж, цахим сургалтын орчныг сайжруулах замаар Улсын хэмжээнд сурагчдын нийгэм-эдийн засаг, газар зүйн байршлаас хамааралгүйгээр тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилттой төсөл юм.

- Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:
 - Цэцэрлэг: Орон нутгийн 8 байршил болон нийслэлд 1, нийт 9 цэцэрлэг шинээр барьснаар 1,100 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нөхцөл бүрдэнэ.
 - Сургууль: Нийт 18,880 хүүхдийн хүчин чадал бүхий 32 сургууль барьснаар 37,760 хүүхэд ерөнхий боловсролд тэгш хамрагдах боломжтой болно.
- Цахим сургалтын хөгжүүлэлтийн хүрээнд:
 - Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг дэмжих цахим контентыг 25 багц сэдвийн хүрээнд боловсруулж, Улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг 250 мянга орчим хүүхэд, Багшийн чадавхыг бэхжүүлэх сургалтад 1,200 багш тус тус хамруулах боломж бүрдэнэ.
 - Ерөнхий боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөртэй нийцүүлэн Мэдлэ цахим сангийн 10,279 хичээлийг шинэчилнэ.

Олон Улсын Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас 2022 онд явуулсан PISA үнэлгээгээр Монгол Улсын хот, хөдөөгийн суралцагчдын сурлагын

амжилтад дунджаар 2.5 жилийн ялгаа байгааг тогтоосон. Мөн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр дээд болон доод 25 хувьд хамаарах сурагчдын хооронд 5 жилийн ялгаа ажиглагдсан бөгөөд доод бүлгийн сурагчдын дийлэнх нь хөдөө орон нутгийн буюу сумдын сургуулиудад хамрагдаж байгааг тэмдэглэсэн байна. Иймд орон нутгийн боловсролын хүртээмж, чанарт онцгойлон анхаарч, хөрөнгө оруулснаар хөдөлмөрийн зах зээлд мэргэжлийн болон дээд боловсролтой, өрсөлдөх чадвартай ажиллах хүч нэмэгдэж, хөдөлмөрийн бүтээмжийг өсгөж дунд болон урт хугацаанд татварын орлогыг нэмэгдүүлж, нийгмийн халамжийн зардлыг бууруулах үр нөлөөг үзүүлнэ.

Үүнээс гадна Монгол Улсын хүн амын өсөлт, ялангуяа хүүхдийн тоо нэмэгдэхийн зэрэгцээ хот суурин газрын хүн амын нягтаршил өсөж байгаа нь боловсролын дэд бүтцийн эрэлтэд шууд нөлөөлж байна. Энэхүү нөхцөл байдал нь анги дүүргэлтийг нэмэгдүүлж, сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байгаа тул сургуулийн ээлжийн тоог бууруулах, анги дүүргэлтийг багасгах, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлэх нь нэн шаардлагатай арга хэмжээ юм.

Нийгэм, жендерийн үзүүлэлтийн хувьд хүүхдийн нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн онцлог хэрэгцээг хангасан орчныг бүрдүүлж, ялгаварлагдах саад бэрхшээлийг арилгаж, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн сургуульд суралцах боломж нэмэгдэж, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хамран сургалт нэмэгдэхэд тодорхой хувь нэмрээ оруулах боломжтой.

Нийслэлийн өндөр ачаалалтай сургуулиудын анги дүүргэлтийг бууруулах, орон нутгийн сургуулийн чанарыг сайжруулах нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцэж, боловсролын хүртээмжийг орон даяар тэгш хангах нөхцөлийг бүрдүүлнэ. Уг боловсролыг дэмжсэн төлөвлөлт нь залуучууд, ард иргэдийн шилжилт хөдөлгөөнийг бууруулан, орон нутгийн эдийн засаг ба хүн амын тогтвортой байдлыг дэмжиж, улмаар бүс нутгийн хөгжлийн зөрүүг багасгаж, нийслэл болон томоохон хотуудын нийгмийн, дэд бүтцийн дарамт болон замын түгжрэлийг хөнгөрүүлнэ.

Сургууль, цэцэрлэгийн барилгын норм стандартын шинэчлэлийн хүрээнд сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд үүний хүрээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулж, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулж эхэлсэн. Байгаль орчны боловсролыг сургалтын хөтөлбөрт өргөн хүрээнд тусгаснаар ирээдүйн иргэдийн байгальд ээлтэй амьдралын хэв маяг төлөвшиж, эрдэс баялгийн нөөцийг хэмнэх, хог хаягдлыг бууруулах дадал суралцагчдад хэвших боломж үүснэ.

Хүүхдийн нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн онцлог хэрэгцээний шаардлагыг сургууль, цэцэрлэгийн барилгад шийдэж өгснөөр дараах үр дүн гарна гэж тооцож байна:

- Хувь хүний онцлог хэрэгцээ хангагдсанаар хүүхдийн суралцах чадвар сайжирч, хүүхдүүд өөрсдийн онцлогт тохирсон орчинд суралцсанаар илүү үр дүнтэй суралцаж, урт хугацаанд суралцах чадвар нь сайжирна;

- Нийгмийн ур чадвар дээшилж, хүүхдүүд олон найз нөхөдтэй болж, харилцааны ур чадвараа сайжруулна;

- Өөртөө итгэх итгэл нэмэгдэж, хүүхдүүд өөрсдийгөө үнэлж, хамт олондоо хамааралтай гэж мэдэрснээр өөртөө итгэх итгэл нь нэмэгдэнэ;

- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хамран сургалт нэмэгдэж, боловсролын хүртээмж болон боловсролын чанар дээшлэхэд хувь нэмрээ оруулна.

3.Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Төслийг хэрэгжүүлснээр боловсролын салбарын хүртээмж, чанар нэмэгдэж, урт хугацаанд улс орны хөгжлийн стратегийн зорилтыг дэмжих дараах салбарын болон нийгэм, эдийн засгийн үр ашиг бий болно. Үүнд:

- Боловсролд хамрагдах иргэдийн хувь өссөнөөр хүн амын боловсролын түвшин, нэмэгдэж, хүний хөгжлийн индексийн түвшинд ахиц гарна.
- Боловсролд ялгаатай хэрэгцээтэй хүний оролцоо, хамрагдалтыг өсгөх замаар тэдний орлого, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх, нийгмийн үйл ажиллагаанд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлнэ.
- Иргэд боловсролд хамрагдсанаар илүү ур чадвар эзэмшиж, хөдөлмөрийн бүтээмжээ нэмэгдүүлнэ. Боловсрол сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан жил нь хөдөлмөр эрхлэлт, орлогод шууд хамааралтай байдаг. Сургуульд сурсан жил нэгээр нэмэгдэхэд хөдөлмөр эрхлэх магадлал нь 6.5 хувиар нэмэгддэг.
- Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, чанарыг сайжруулснаар ерөнхий боловсролд хийх хөрөнгө оруулалт аажмаар буурна. Шинэ барилга байгууламжийн ажилд орон нутгийн барилгын компани, ханган нийлүүлэгчид хөдөлмөрийн зах зээлд шууд оролцож, ажлын байр нэмэгдэнэ;
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих буюу цэцэрлэгийн хүрэлцээ сайжрах нь бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн ажиллах боломжийг бүрдүүлж, улмаар өрхийн орлогыг өсгөж, хөдөлмөрийн зах зээлд эерэг нөлөө үзүүлнэ;
- Хүүхдээ хол замд сургууль, цэцэрлэгт зөөхөд зарцуулдаг цаг багасаж, эцэг эхийн бүтээмж сайжирна.

---oOo---

“МОНГОЛ УЛСЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ” ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Хөдөө аж ахуйн салбар нь дотоодын үйлдвэрлэл, импортыг орлох болон экспортод голлох үүрэг гүйцэтгэх мөн хөдөө орон нутагт амьдарч, хөдөө аж ахуй эрхэлдэг нийт хүн амын 30 орчим хувийн орлого, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой салбар юм. Монгол Улс эдийн засгийг төрөлжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудын нэг нь хөдөө аж ахуй бөгөөд тус салбарын бүтээмж, нэмүү өртгийг нэмэгдүүлэх шаардлага тулгараад байна.

Түүнчлэн хөдөлмөрийн зах зээлийн зарим салбар, тэр дундаа хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүчний хомсдол үүсээд байгаа бөгөөд хүний нөөцийн тоо, чанарын хувьд ч мөн дутагдалтай байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас 2023 онд явуулсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн зах зээлийн үнэлгээ”-ний дүнгээр хөдөө аж ахуйн салбарын нийт ажиллах хүчний хувь 2018 онд 26.7 байснаас 2022 онд 24.9 хувь болж буурсан дүнтэй байна. Сүүлийн таван жилийн бүтээмжийн өсөлтийн чиг хандлагыг үндэслэн хөдөө аж ахуйн салбарыг авч үзвэл тус салбарын хөдөлмөрийн бүтээмж улсын дунджаас 7-14 жилээр хоцорч байна. Үүнээс гадна хөдөө аж ахуйн салбарын дундаж цалин улсын дунджаас 24 хувиар доогуур байгаа нь уг салбарт ажиллах хүчний нийлүүлэлт буурах шалтгаануудын нэг болж байна.

Хөдөлмөр эрхлэх сонирхолтой иргэд олон байгаа хэдий ч ажил олгогч болон ажил хайгчдыг хооронд нь холбох механизм сул байгаагаас шалтгаалан ажиллах хүчний дутагдал, ажилгүйдэл тулгамдсан асуудал хэвээр байсаар байна. Тухайлбал, ажил олгогчдын 81.6 хувь нь ажилтан хайхдаа албан бус сувгуудыг ашигладаг бөгөөд үүнээс 40.8 хувь нь найз нөхөд, хамаатан саднаар дамжуулан, 35.8 хувь нь нийгмийн сүлжээгээр хайж байгаа бол зөвхөн 5.0 хувь нь их, дээд боловсролын байгууллагуудтай холбогддог ба албан ёсны хөдөлмөрийн бирж ашиглах нь тун ховор байна.

Сүүлийн 5 хичээлийн жилийн мэдээгээр жил бүр мал аж ахуй, газар тариалангийн 17 мэргэжлийн хөтөлбөрөөр нийт 1000 орчим төгсөгч төгсөгч төгсдөгөөс хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчийн тоо буурч байна. Гэтэл эсрэгээрээ 2024 оны хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаагаар төгсөгчийн эрэлт нэмэгдэхээр байна. Хэрэв 2030 он гэхэд эрэлтэд шаардагдах тооны мэргэжилтэн бэлтгэж төгсгөнө гэвэл боловсролын сургалтын байгууллагын барилгын хүчин чадлыг өргөтгөж, хөдөө аж ахуйн мэргэжлийн хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх, дадлагын бааз, тоног төхөөрөмж, шинэ техник, технологийг нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн мэргэжлийн багш нарыг хөгжүүлэх, сургалтаа ажил олгогчтой хамтран уян хатан байдлаар бэлтгэж, сургах шаардлагатай болно.

Цаашлаад хөдөө аж ахуйн салбарт хүний нөөцийг татан оролцуулах, сургах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр бодлогын орчин, стратегийг боловсруулах, мөн шинэ технологи, инновацыг нэвтрүүлэн бүтээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх шаардлага нэн даруй тулгарч байна.

Мөн Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд төвийн бүс нутгийн тэргүүлэх салбаруудын нэг нь хөдөө аж ахуйн салбар гэж тусгагдсан бөгөөд орон нутгийн техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагуудыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулах хүрээнд Дархан-Уул, Сэлэнгэ аймагт салбар хоорондын сургалт үйлдвэрлэлийн төвийг байгуулах төлөвлөгөө Засгийн газраас хэрэгжүүлж байна. Үүний дагуу Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.4. төрийн өмчийн зарим их сургууль, политехник коллежийг түшиглэн техникийн болон дээд боловсролын шаталсан тогтолцоо бүхий сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор их сургууль, төрөлжсөн коллежийг бүсүүдэд хотхон хэлбэрээр хөгжүүлэхээр заасан байна.

Иймд Төвийн бүсийн хөдөө аж ахуйн төв болох Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн политехник коллеж дээр дадлагын бааз, чадамжийн төвийг хувийн хэвшилтэй хамтран, түншлэлийн хүрээнд байгуулах нь техник, технологи, тоног төхөөрөмжийн хөгжлийн зөрүүг арилгах, салбарт шинэ мэргэжилтэн, ахисан түвшний ур чадвартай ажиллах хүчнийг богино хугацаанд бэлтгэхэд ихээхэн ач холбогдолтой. Дархан-Уул аймгийн политехник коллежид хөдөө аж ахуйн үндсэн 4 чиглэл буюу мал аж ахуй, газар тариалан, хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр төрөлжүүлэн богино хугацааны нарийвчилсан мэргэжил олгох нийт 35 сургалтын хөтөлбөр, газар тариалангийн 9 хөтөлбөр, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр нийт 11 мэргэжлийн чадамжид суурилсан сургалтыг явуулах боломжтой болно. Эдгээр сургалтыг орон нутаг дахь мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр үйлдвэрлэл эрхэлдэг хувийн хэвшил, Хөдөө аж ахуйн их сургууль, төрийн болон төрийн бус байгууллага, мах, сүүний жижиг дунд үйлдвэр, фермерийн аж ахуй, Дархан нэхий, Дархан минж ХХК болон мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж, төр хувийн хэвшлийн түншлэлийн сайн туршлагыг бий болгоно.

Хоёр. Бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.1 дэх зорилтод бүсийн төв, аймаг, орон нутаг дахь ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, технологийн коллеж, их, дээд сургуулиудын үүрэг, оролцоо нэмэгдүүлэх, 2.6 дахь зорилтод хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэж, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэхээр тус тус туссан.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд хөдөө аж ахуйн төрөлжсөн бүс нь төвийн бүс байхаар зааж, бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулахаар туссан.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.4-т төрийн өмчийн зарим их сургууль, политехник коллежийг түшиглэн техникийн болон дээд боловсролын шаталсан тогтолцоо бүхий сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор их сургууль, төрөлжсөн коллежийг бүсүүдэд хотхон хэлбэрээр хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн болно.

Гурав. Төслийн санхүүжилт, нөхцөл

Төслийг Азийн Хөгжлийн Банкны 20 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлнэ. Монгол Улсын Засгийн газрын оролцооны тухайд нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт санхүүжүүлэхээр урьдчилан тооцоолов.

№	Зардал	Төсөвт өртөг /сая ам.доллар/
A	Төвийн бүсэд төрөлжсөн жишиг Политехник коллеж, дэд бүтцийг бий болгох	16.45
B	Хөдөө аж ахуйн ур чадвартай ажиллах хүчнийг бэлтгэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах	0.60
C	Хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн салбар дундын зохицуулалтыг бий болгох	0.50
D	Магадалшгүй ажлын зардал	2.3
	Нийт	20.0

Дөрөв. Төслийн зорилго, хугацаа, байршил, хэрэгжүүлэх арга хэмжээ, үр дүн

Төслийн зорилго: Төсөл нь хөдөө аж ахуйн салбар дахь хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлж, ухаалаг технологи, инновацыг нэвтрүүлэх мэргэжлийн болон техникийн боловсролын төрөлжсөн жишиг сургалтын тогтолцоог хөгжүүлэх зорилготой. Энэхүү зорилгыг дараах зорилтын дагуу хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хөдөө аж ахуйн төрөлжсөн сургалт, дэд бүтэц бүхий жишиг политехник коллежийг бий болгох,
2. Хөдөө аж ахуйн ажлын байрны эрэлт, хэрэгцээнд нийцсэн шинэ техник, технологийн ур чадвартай ажиллах хүчнийг бэлтгэх,
3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн уялдааг хангах, холбогдох талуудын хамтын ажиллагаа, түншлэлд суурилсан салбар дундын зохицуулалтыг бий болгох.

Төслийн хэрэгжих хугацаа: 2026–2031 он

Төслийн хэрэгжих байршил: Дархан-Уул аймаг.

Төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

Бүрэлдэхүүн хэсэг 1. Төвийн бүсийн Политехник коллежийг хөдөө аж ахуйн төрөлжсөн жишиг политехник коллежийг бий болгож дэд бүтэц, дадлагын бааз, чадамжийн төв, хичээлийн болон дотуур байрыг төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилан өргөтгөж, шинээр байгуулан, (БНХАУ-ын ЛАБУН загварын) ухаалаг техник, технологийг суурилуулах.

Бүрэлдэхүүн 2. Хөдөө аж ахуйн ажиллах хүчнийг бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх, ухаалаг технологи, инновацын ур чадварыг тусган шинэчлэх, сургалтын зохион байгуулалтыг уян хатан болгож, ажлын байранд суурилсан загварыг нэвтрүүлэх.

Бүрэлдэхүүн 3. Хөдөө аж ахуйн салбар дахь инновац, технологийн нэвтрэлт, хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн дүн шинжилгээ хийх салбар дундын чадавхыг бэхжүүлэх.

Төслийн үр дүн:

Төвийн бүсэд хөдөө аж ахуйн төрөлжсөн сургалт, дэд бүтэц бүхий жишиг политехник коллежийг байгуулснаар мах болон сүүний үхрийн аж ахуйн технологи, мал үржүүлэг, бэлчээр ашиглалт, нөхөн сэргээлт, тэжээл тариалах, тэжээх, малын өвчин, эмийн зохистой хэрэглээ, гахай, шувуу, зөгийн аж ахуй, тоног төхөөрөмжийн засварчин, гагнуурчин болон GPS/GIS-тэй машин механизмыг удирдах, оношлох ур чадвар олгох сургалтыг 35 мэргэжлийн чиглэлээр зохион байгуулж, жилдээ 1900 орчим мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ.

Мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр нийт 11 мэргэжлийн сургалтыг явуулна. Үүнд: түүхий эд бэлтгэлийн стандарт, арьс шир, ноос, ноолуур, ээрмэл, нэхмэл, сүлжмэлийн боловсруулах үйлдвэрийн ажилтан, боловсруулсан арьс шир болон бэлэн бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрийн дэвшилтэт болон байгаль орчинд ээлтэй тогтвортой үйлдвэрлэлийн технологийн сургалтыг малчин, аж ахуй эрхлэгч, хоршоологч, иргэдэд сургалт зохион байгуулан, жилдээ дор хаяж 900 орчим мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн зохистой дадал, үр, тариа, тэжээлийн ургамал, ил талбайн таримал, хамгаалагдсан хөрсний таримлын технологи, жимс жимсгэнэ тариалах, ургамал хамгаалал, ухаалаг технологид суурилсан газар тариалангийн эдийн засгийн баримжаа олгох гэсэн 9 чиглэлд мэргэжлийн чадамжид суурилсан хөтөлбөрөөр жилдээ дор хаяж 450 орчим хүнд мэргэжилтэй ажилтан сургаж төгсгөнө.

Хүнсний чиглэлээр мах махан бүтээгдэхүүний боловсруулалт, сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулалт, хүнсний салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах чиглэлийн мэргэжлийн чадамжид суурилсан ур чадвар олгох сургалтыг малчин, аж ахуй эрхлэгч, фермер эрхлэгчид, хоршооны гишүүд, шинэ төгсөгч, аймаг, сумдын шинэ мэргэжилтнүүдийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн сургалт зохион байгуулна. Нэг удаагийн сургалтад 15-25 суралцагч хамрагдах бөгөөд 3 мэргэжлээр жилд дор хаяж 300 орчим суралцагчид мэргэжлийн ур чадвар олгоно.

Түүнчлэн төвийн бүсэд бий болгосон хөдөө аж ахуйн төрөлжсөн сургалт, дэд бүтэц бүхий жишиг коллежийн загварыг ашиглан бусад бүсүүдэд эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр төрөлжсөн политехник коллежуудыг бий болгоно.

---o0o---

“МОНГОЛ УЛСЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ” ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.Өнөөгийн нөхцөл байдал, төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

21 дүгээр зуун, нийтээр мэдлэгийн эдийн засагт шилжиж байгаатай уялдан аж үйлдвэржилтийн үеийн ажилчнаас мэдээллийн эрин үеийн чадамжтай ажилчин бэлтгэх мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын цогц системийг хэрэгжүүлэх шаардлага улам нэмэгдэж байна. Иймд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбар нь мэргэжлийн сургалтын байгууллагууд төдийгүй ерөнхий боловсролын дунд, ахлах болон дээд боловсролын хөтөлбөрийн шатлалыг оновчтой хэрэгжүүлэх, ажлын байран дахь сургалт, мэргэшил дээшлүүлэх, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх сургалтын олон төрөл хэлбэрээр хэрэгжүүлэх, ажиллах хүчнийг тасралтгүй мэргэшүүлэх боловсролын зорилтыг хэрэгжүүлж байна.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалт (цаашид “МБТБС” гэх) нь чадамж, ур чадварыг албан болон албан бус хэлбэрээр эзэмшүүлж, боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн шууд уялдааг хангадаг боловсролын онцлог салбаруудын нэг юм. Иймдээ ч сургалтын хөтөлбөр, орчин, сургах арга барил, нийгмийн түншлэлийн хамтын ажиллагаа гэсэн онцлог шинжүүдтэй, тэдгээрт хөрөнгө оруулалт маш ихээр шаарддаг салбар болно.

Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Эрдэм боловсролтой Монгол хүн” зорилгыг хэрэгжүүлэх, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх хүрээнд 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбарыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой зорилтуудыг тусгасан. Тухайлбал: 1.3.3.5-д “Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, 2 аймагт салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн баазыг байгуулна” гэж тусгасан.

Мөн ЮНЕСКО-ийн ЮНЕВОК¹ олон улсын байгууллагаас улс орнуудын МБТБС-ыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн 2022-2029 оны стратегийн төлөвлөгөөнд:

- МБТБС ба ур чадварын тогтолцоонд дижитал шилжилт хийх;
- Насан туршийн суралцахуйн эрхийн тогтолцоо, түүнийг дэмжих;
- Автоматжуулалт, дижиталчлагдсан хөдөлмөрийн зах зээл хөдөлмөрийн зах зээл дэх ур чадварын зөрүүг багасгах;

¹ ЮНЕСКО-ийн Техникийн болон мэргэжлийн боловсрол хариуцсан байгууллага

-Технологийн хувьсгалын эрин үеийн боловсрол, ур чадварын сургалт, насан туршийн суралцахуйн бодлого хэрэгжүүлэх;

-МБТБС-ын байгууллагуудад бизнес эрхлэх ур чадварын сургалтыг хөгжүүлэхийг улс орнуудад зөвлөж буй.

2.Төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүн, ач холбогдол

Төслийг хэрэгжүүлснээр боловсролын салбарт томоохон дэвшил гарч, хүний нөөцийн чадавх сайжирна.

- **Чанар, хүртээмж сайжрах:** Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн жишиг сургалтын төв, дадлагын бааз, дотуур байртай болсноор орон нутгийн залуусын чанартай боловсрол эзэмших боломж нэмэгдэнэ. Энэ нь хот, хөдөөгийн боловсролын ялгааг багасгахад чухал нөлөөтэй.

- **Хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн боловсрол:** Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн сургалтын хөтөлбөрийг шинэчилж, ногоон, дижитал, автоматжуулалт зэрэг орчин үеийн чиг хандлагыг тусгаснаар төгсөгчид ажлын байран дээр шууд ашиглагдах мэдлэг, чадвартай болно. Энэ нь ажилгүйдлийг бууруулах, ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулна.

- **Насан туршийн боловсролыг дэмжих:** MOOC (Massive Open Online Courses) платформыг нэвтрүүлснээр иргэд ажиллангаа, оршин суугаа газраасаа үл хамааран мэргэжил дээшлүүлэх, шинэ мэргэжил эзэмших боломжтой болно. Энэ нь насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлж, иргэдийн хувийн болон мэргэжлийн хөгжлийг тасралтгүй дэмжинэ.

- **Багшийн чадавх дээшлэх:** Бүс нутгийн багш нарын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулснаар тэдний мэдлэг, арга зүй сайжирч, улмаар сургалтын чанарт эерэг нөлөө үзүүлнэ.

3.Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Төслийг хэрэгжүүлснээр эдийн засагт дараах шууд болон шууд бус ашиг бий болно:

- **Ажиллах хүчний бүтээмж нэмэгдэх:** Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвартай мэргэжилтнүүд бэлтгэгдсэнээр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны бүтээмж дээшилнэ. Энэ нь улсын эдийн засгийн өсөлтөд шууд нөлөөлөх хүчин зүйл юм;

- **Шинэ ажлын байр бий болох:** Төслийн хүрээнд шинэ сургалтын төв, дадлагын бааз байгуулах, шинэ мэргэжил нээх нь багш, ажилтан, үйлчилгээний ажилтны ажлын байрыг нэмэгдүүлнэ;

- **Мөнгөн урсгалын хуримтлал:** Сургалтын байгууллагууд шинэ тоног төхөөрөмжөөр хангагдаж, багш нар нь мэргэжил дээшлүүлснээр нэг суралцагчид ногдох сургалтын өртөг буурах, төгсөгчдийн ажлын байртай болох хувь нэмэгдэх зэрэг

нь эдийн засгийн хувьд үр ашигтай. Мөн иргэд орон нутагтаа, ажиллангаа суралцсанаар хот руу шилжих хөдөлгөөн, үүнтэй холбоотой зардал буурна;

• **Хөрөнгө оруулалтыг татах боломж:** Орчин үеийн, ур чадвартай мэргэжилтнүүд бүхий ажиллах хүчний зах зээл нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах гол шалтгаан болдог. Тогтвортой хөгжилд чиглэсэн мэргэжилтнүүдийг бэлтгэж чадвал тухайн бүс нутагт үйлдвэр, аж ахуйн нэгж байгуулах сонирхол нэмэгдэнэ.

---o0o---

“МОНГОЛ УЛСЫН ГАМШГИЙГ СӨРӨН ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Монгол орны нутаг дэвсгэрт үер, зуд, салхи шуурга, ой, хээрийн түймэр зэрэг байгалийн аюулын давтамж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр нэмэгдэхээс гадна олон улсын хөл хориотой хүн, малын гоц халдварт өвчний шинэ төрлийн аюулууд тохиолдож, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

2005-2014 онд жилд дунджаар 3,362 аюулт үзэгдэл осол тохиолдож, 214 хүн амь насаа алдаж байсан бол 2015-2024 онд жилд дунджаар 4,550 аюулт үзэгдэл, осол тохиолдож, “КОВИД-19” цар тахлаас бусад аюулт үзэгдэл ослоор 251 хүн амь насаа алдаж байгаа нь аюулт үзэгдэл ослын тохиолдлын тоог 35.3 хувь, амь насаа алдсан хүний тоог 16.8 хувиар тус тус өссөн байгааг харуулж байна. Үүнээс үзэхэд дараагийн 10 жилд энэ өсөлтөөр тооцвол 2025-2034 онд жилд дунджаар 6,156 гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдож, 293 хүн амь насаа алдах магадлалтай гэж үзэж болохоор байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас сүүлийн 80 жилд мэдэгдэхүйц дулаарч, гадаргын температур 2.4°C-аар ихсэн, хүйтэн өдрийн тоо цөөрч, халуун өдрийн тоо нэмэгдэн, хуурайших хандлага давамгайлж байна. Ингэснээр ургамлын ургалтын хугацааны хур тунадас буурч, аадар борооны хувь хэмжээ нэмэгдэж байгаагаас нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн. Цаашид Монгол орны уур амьсгал дэлхийн дундажтай харьцуулбал ихээхэн эрчимтэй өөрчлөгдөж хуурайших, цаг агаарын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлийн эрчим, давтамж нэмэгдэхээр байна.

Монгол орны нутаг дэвсгэр Төв Азийн газар хөдлөлтийн идэвхтэй бүс нутагт оршдог бөгөөд ХХ зуунд 8.0 магнитудын газар хөдлөлт 4 удаа, 7.0 магнитудын хүчтэй газар хөдлөлт 20 орчим удаа болж байсан. Сүүлийн жилүүдэд улсын хүн амын хагас нь амьдардаг Улаанбаатар хот орчмын бүс нутагт тохиолдох газар хөдлөлтийн идэвхжилт эрчимтэй өсөж байна. Тухайлбал, 2001-2010 онд магнитуд нь 3,0 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 50 удаа тохиолдож байсан бол 2011-2022 оны хувьд 72 удаа болж нэмэгдсэн. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка)-аас 2013 онд Улаанбаатар хотын хэмжээнд хийсэн газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээгээр хот орчмын идэвхтэй хагарлууд дээр 6.6-7.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт болоход хотын нийт барилгажсан хэсгийн 30 хувь нурж, ойролцоогоор 40-60 мянган иргэд өртөж амь нас, эрүүл мэндээрээ хохирох тооцоог гаргасан.

Ялангуяа хүүхэд, өндөр настан, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшгийн эмзэг байдал өндөр, орон нутгийн захиргаа, боловсролын байгууллага, эрүүл мэндийн салбар, хувийн хэвшлийн бэлэн байдлын түвшин хангалтгүй байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд бүх шатны байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийтийн оролцоо манай улсад хангалтгүй байдаг бөгөөд иргэд, аж ахуйн

нэгж, байгууллагын дийлэнх хувь нь онцгой байдлын байгууллага л авран хамгаалах ёстой гэсэн хандлагатай байна.

Онцгой байдлын байгууллагын хүч хэрэгсэл дутмаг, ялангуяа алслагдсан сум, суурин газарт гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээ тэр бүр хүрч чадахгүй байгаа.

Иймд үндэсний хэмжээнд гамшгаас хамгаалах мэдлэг, боловсролыг хүн бүрд олгох, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, иргэд олон нийтийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, өөрөө өөрсдийнхөө аюулгүй байдлаа хангах, хүн бүр авран туслагч байх гэсэн хандлагыг төлөвшүүлэх шаардлага тулгарч байна.

Хоёр. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал

-“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Зорилт 7.3-т “Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлж, уг зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний 7.3.14-т “Гамшгийн үеийн үйл ажиллагааг орон нутгийн зөвлөлөөс мэргэжлийн түвшинд гүйцэтгэх үндэсний чадавхыг бэхжүүлж, орон нутагт анги, салбарыг үе шаттайгаар байгуулна”, 7.3.15-д “Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулж, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлнэ”, 7.3.20-д “Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хамгаалах үйл ажиллагаанд сансрын болон бусад дэвшилтэт арга технологи, техник хэрэгсэл, багаж төхөөрөмж нэвтрүүлж, гамшигтай тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүргэнэ”, 7.3.23-т “Хот суурин газарт гал түймэр унтраах ангийг стандартад нийцүүлэн нэмж байгуулах, гал түймрийг илрүүлэх, унтраах чиглэлд дэвшилтэт арга технологи, шинэ техник, багаж төхөөрөмжийг нэвтрүүлнэ”, 7.3.24-т “... тусгай чиг үүрэг бүхий нисэхийн нэгж байгуулж, нисдэг тэрэг (автожир)-ний хангалтыг үе шаттайгаар хийнэ” гэж;

-Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 7.3.3-т “орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, тогтолцоог бэхжүүлнэ” гэж;

-Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн **“4.4.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм” зорилтын 4.4.4.4-т** “Гал түймэр унтраах болон эрэн хайх, аврах нэгжийг орон нутагт өргөтгөж, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ”, 4.4.4.11-д “Гамшгийн эрсдэлийн тухай ойлголт, мэдлэгийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг бодитойгоор нэмэгдүүлнэ”, 4.4.4.16-д “Гамшгийн үед хариу арга хэмжээ авах үндэсний чадавхыг сайжруулж, Олон улсын эрэн хайх, аврах зөвлөлдөх бүлэг /INSARAG/-ийн стандартад нийцсэн дунд түвшний ангиллын багтай болж, аврах ажиллагааны дэвшилтэт арга технологи, шинэ техник, багаж төхөөрөмжийг нэвтрүүлнэ” гэж,

-Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн 3.1-д “Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл

ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх”, 4.1-д “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлж, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх” гэж,

-Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний 3.17 дахь Гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх зорилтын 3.17.1.1-д “Дэвшилтэт технологи, инновацад суурилсан гамшгаас хамгаалах, эрт сэрэмжлүүлэх зарлан мэдээллийн нэгдсэн систем байгуулах”, 3.17.1.3-т “ Онцгой байдлын техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх” гэж тус тус заасан.

Гурав. Төсөвт өртөг

№	Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр	Зориулалт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (сая ам.дол)	Нийт үнэ (сая ам.дол)
1	Амьсгалын бие даасан төхөөрөмжийн автомашин	Гал түймрийн үед амьсгалын бие даасан төхөөрөмжийг цэнэглэх, ариутгах, нөөц агаар хадгалах саваар хангах	7	Ширхэг	0.35	2.45
2	Гэрэл, холбооны автомашин	Гал түймэр унтраах болон аврах ажиллагааны үед газар дээр нь холбоо зохион байгуулах, Гал түймрийн голомт болон ослын бүсийг гэрэлтүүлгээр хангах	15	Ширхэг	0.3	4.5
3	Ус тээвэрлэгч автомашин	Гал түймэр унтраах үндсэн албаны автомашиныг гал түймэр унтраах бодисоор хангах	45	Ширхэг	0.28	12.6
4	Утаа сорогч автомашин	Барилга байгууламжид хуримтлагдсан утааг гаргах, саармагжуулах	3	Ширхэг	0.3	0.9
5	Гал унтраах дрон	Гал түймэр унтраах автомашинд суурилсан өндөр байшин барилгад гарсан гал түймрийг унтраах зориулалттай том оврын дрон	3	Ширхэг	1.35	4.04
6	Амьсгалын бие даасан төхөөрөмж	Гал түймрийн голомтод алба хаагчийг хүчил төрөгчөөр хангах, амьсгалах эрхтэн хамгаалах	1000	Ширхэг	0	2.5
7	Амьсгалын бие даасан төхөөрөмжийн битүүмжлэл шалгах төхөөрөмж	- Амьсгалын бие даасан төхөөрөмжийн нүүрвч маск, агаараар хангах хавхалга, өндөр даралт, нам даралтын хоолой, үүргэвчийн редакторын битүүмжлэлийг туршин шалгах	22	Ширхэг	0.08	1.65
8	Агаар хадгалах савны битүүмжлэл шалгах төхөөрөмж	Агаар хадгалах сав (Баллон)-ны битүүмжлэлийг туршин шалгах	22	Ширхэг	0.09	1.87
9	Амьсгалын бие даасан төхөөрөмжийг цэвэрлэх, ариутгах төхөөрөмж	Амьсгалын бие даасан төхөөрөмжийн нүүрвч маскийг зориулалтын бодисоор угаах, ариутган хатаах	22	Ширхэг	0.11	2.42
Нийт			1,139			32.93

№	Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр	Зориулалт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (сая ам.дол)	Нийт үнэ (сая ам.дол)
ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААНЫ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ХАМГААЛАХ ХУВЦАС, БАГАЖ ХЭРЭГСЭЛ						

1	Эрэн хайх, аврах ажиллагааны автомашин /Дунд оврын/	Эрэн хайх, аврах ажиллагааны тусгай зориулалтын тоноглолтой автомашин /иж бүрдэл/	45	Ширхэг	0.20	9.00
2	Өндрөөс аврах ажиллагааны автомашин /том оврын/	Өндрөөс аврах ажиллагаанд ашиглах тусгай зориулалтын, шат бүхий автомашин	8	Ширхэг	0.40	3.22
3	Гүний уурхайн аврах ажиллагааны иж бүрдэл автомашин	Бүрэн тоноглогдсон гүний уурхайн аврах ажиллагааны авто машин	1	Ширхэг	3.50	3.50
4	Шуурхай албаны автомашин /бага оврын/	Эрэн хайх, аврах ажиллагааны тусгай зориулалтын тоноглолтой автомашин /иж бүрдэл/	80	Ширхэг	0.06	4.80
5	Хими, цацрагийн ослын үед ашиглах шуурхай албаны автомашин	Хими, цацрагийн ослын голомтод ашиглах багаж, тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгсэл, бусад хэрэглэгдэхүүнээр тоноглогдсон, алба хаагчдын зорчих хэсэгтэй байх	6	Ширхэг	0.50	3.00
6	Бартаат замын дөрвөн дугуйт	Алба хаагч болон ачаа тээшийг тээвэрлэх зориулалттай	11	Ширхэг	0.01	0.13
7	Авто чирэгч / 6х4 /	Гамшиг, цар тахал, ослын үед дэлгэх хээрийн эмнэлгийн тээвэрлэлтийг зохион байгуулах	10	Ширхэг	0.06	0.60
8	Тавцант чиргүүл /~40 тн/	Гамшиг, цар тахал, ослын үед дэлгэх хээрийн эмнэлгийн тээвэрлэлтийг зохион байгуулах	10	Ширхэг	0.02	0.23
9	Кран /30 тн/	Хээрийн эмнэлэг болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжийн тээвэрлэлт, ачилт, буулгалтыг зохион байгуулах болон хойшлуулшгүй сэргээн босгох хариу арга хэмжээг зохион байгуулах	5	Ширхэг	0.10	0.50
10	Кран, тэвштэй автомашин /8 тн/	Үйлдвэрийн осол болон техникийн гаралтай осол аваарын үед шуурхай хариу арга хэмжээг зохион байгуулах	2	Ширхэг	0.05	0.09
11	Авто ачигч тээвэрлэгч /Ковш - 3.5м3/	Нуранги болон бусад ослын үед эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах, хойшлуулшгүй сэргээн босгох	8	Ширхэг	0.08	0.66
12	Экскаватор	Бүх төрлийн аврах, сэргээн босгох ажиллагаанд ашиглагдана	21	Ширхэг	0.05	1.05
13	Бага оврын олон ажиллагаатай гинжит трактор	Нуранги, болон бусад ослын үед эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах	70	Ширхэг	0.05	3.50
14	Өндөр даралтын бохир ус сорогч	- Усны осол болон үерийн голомтод үүрэг гүйцэтгэх	10	Ширхэг	0.07	0.68
15	Техник засварын тоног төхөөрөмж /иж бүрэн/	- Онцгой байдлын албаны автомашин техникт мэргэжлийн засвар үйлчилгээг зохион байгуулах хүчин чадал бүхий иж бүрэн тоног төхөөрөмж	10	Ширхэг	0.03	0.30

16	Том оврын шатахуун хөдөлгүүрт нисгэгчгүй нисэх төхөөрөмж	200км алслалтад 200кг хүртэлх ачаа тээвэрлэх, зориулалттай бензин хөдөлгүүртэй, алсын эрэн хайх аврах ажиллагааны зориулалт бүхий тоноглолтой дрон	3	Ширхэг	2.80	8.40
17	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж	Гүний уурхай, туннелд өндөр нарийвчлалтай сканнер хийж, UAV технологийг ашиглан мэдээллийг маш хурдан боловсруулна	8	Ширхэг	0.01	0.10
18	Тээврийн робот	Ослын голомт, эрсдэлтэй орчноос нэрвэгдэгч, алба хаагч, багаж тоног төхөөрөмжийг тээвэрлэх	8	Ширхэг	0.27	2.16
19	Олон төрлийн үйлдэлтэй робот	Ослын голомтод тандалт, судалгаа хийж, CBRN-ын бодисыг илрүүлэх, HazMat-тай харьцах үйл ажиллагааг хийх боломжтой тоноглолтой, HD камер, сайжруулсан гэрэлтүүлэг, лазерын зай хэмжигч бүхий	8	Ширхэг	0.21	1.68
20	Эрэн хайх ажиллагааны камер /Могойн нүд/	Нуранги болон бусад гамшиг ослын голомтод эрэн хайх ажиллагааг зохион байгуулах	32	Ширхэг	0.01	0.22
21	Чичиргээ, чимээ хэмжих багаж	Нурангид нэрвэгдэгчийг эрэн хайх аврах ажиллагаанд ашиглах	24	Ширхэг	0.00	0.03
22	Батарей ажиллагаатай багажийн иж бүрдэл	Эрэн хайх, аврах ажиллагаанд	120	Ширхэг	0.04	4.20
23	Аврах тавцан /цилиндр хэлбэрийн/	10 хүртэлх давхар, 5.0х7.0 х2.5 хэмжээтэй хийлэгдэх хугацаа 54 секунд Дахин хийлэгдэх хугацаа 8 секунд, жин 120 кг	24	Ширхэг	0.01	0.22
	Нийт		524		-	48.27
УСНААС ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААНЫ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ХАМГААЛАХ ХУВЦАС, БАГАЖ ХЭРЭГСЭЛ						
1	Усны дрон	Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах	24	Ширхэг	0.02	0.50
2	Усчин аврагчийн хамгаалах хувцас /иж бүрдэл/	Аврагчийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах	160	Ширхэг	0.01	1.28
3	Усны катер	Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах	5	Ширхэг	0.40	2.00
4	Аврах ажиллагааны завь	Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах	40	Ширхэг	0.02	0.60
5	Тусгай зориулалтын завь	Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах	8	Ширхэг	0.10	0.80
6	Усны мотоцикл	Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах	24	Ширхэг	0.03	0.72
7	Уснаас аврах тавцан	Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах	24	Ширхэг	0.04	0.84

1	Ариутгалын пункт /иж бүрдэл/	6 ба түүнээс дээш бүрэлдэхүүнтэй хими, цацрагийн ослын голомтод ажилласан хүч хэрэгсэлд ариутгал, цэвэрлэгээ хийх	8	Ширхэг	0.12	0.96
2	Зөөврийн цаг уурын станц	Салхины хурд, салхины чиглэл, агаарын температур, харьцангуй чийгшил, барометрийн даралт хэмжигч.	70	Ширхэг	0	0.26
3	Химийн хордолтыг илрүүлэх багаж	Агаар, техникийн гадаргуу, шингэнд байгаа хорт бодис, онцгой үйлчилгээтэй хордуулах бодисыг илрүүлэх, байршлыг хайх, таних багаж. Бүх төрлийн мэдрэлд нөлөөлөх бодис, цэврүүтэгч бодис, цусанд шингэдэг бодис, амьсгал боогдуулах бодисуудыг илрүүлэх таних дөлөн спектрометр бүхий	24	Ширхэг	0.03	0.6
4	Зөөврийн XRF анализатор	X-гау туяагаар хүнд металаар бохирдсон хөрс, бохирдсон материалын бохирдлын хэмжээ болон бохирдуулагч металлыг шууд тодорхойлох камертай багаж	24	Ширхэг	0	0.12
5	Агаарт олон төрлийн хий илрүүлэгч багаж	Агаарт алдагдсан хорт хийн төрөл, хэмжээг тодорхойлох зөөврийн багаж	24	Ширхэг	0	0.11
6	Агаар дахь химийн бодисын найрлага тодорхойлох багажийн иж бүрдэл	Органик бус болон органик хий, уур байгаа эсэхийг хурдан тодорхойлох зориулалттай.	70	Ширхэг	0	0.16
7	Хөрс, уснаас дээж авах иж бүрдэл	Химийн болон биологийн шинжилгээнд зориулж агаар, шингэн болон хатуу дээж цуглуулах иж бүрдэл	24	Ширхэг	0	0.11
8	Шугам хоолойн алдагдал зогсоох иж бүрдэл	Бүх төрлийн шугам хоолойн амсраас алдагдаж буй бодисыг таслан зогсоох зориулалттай иж бүрдэл. Олон төрлийн диаметртай хоолойд зориулсан хавчаар бүхий гадна талын боолт, нэмэлт хөөс материал, нэмэлт резинэн материал, цүнх, түлхүүр багаж, бөглөөснүүдтэй.	24	Ширхэг	0	0.03
9	Химийн бодисын алдагдлын иж бүрдэл	Бүх төрлийн жижиг, том хэмжээтэй савнаас алдагдаж буй бодисын алдагдлыг таслан зогсоох зориулалттай багажийн иж бүрдэл. (Түлхүүр багаж, олон төрлийн бөглөөс, тагтай) Засварын хэрэгсэл: "D" (HMS1503), "D NS" (HMS1503NS) оч гаргадаггүй хэрэгсэл.	24	Ширхэг	0	0.03
10	Химийн бодисын алдагдлыг зогсоох иж бүрдэл	Жижиг, том хэмжээний нүхнээс алдагдаж буй шингэний алдагдлыг боох аргаар богино хугацаанд таслан зогсоох зориулалттай иж бүрдэл багаж.	24	Ширхэг	0	0.04
11	Спектрометр, радиометр	Цацрагийн ослын голомт орчимд тархсан байж болзошгүй гамма, нейтрон цацрагийн эквивалент тун, тунгийн чадлыг тодорхойлох	8	Ширхэг	0.03	0.2

		зориулалттай. Орчны тунгийн эквивалент хурдыг хэмжих хүрээ				
12	Спектрометр	Цацрагийн ослын голомт орчимд тархсан байж болзошгүй бета, гамма цацрагийн эквивалент тун, тунгийн чадлыг тодорхойлох зориулалттай. Цацрагийн тунгийн чадлыг хэмжих хүрээ: 0.01мкЗв/цаг-100мЗв/цаг	8	Ширхэг	0.02	0.18
13	А зэрэглэлийн хамгаалах хэрэгсэл	Химийн хорт болон аюултай бодис алдагдсан орчноос бүрэн тусгаарлах дотор талдаа амьсгалын бие даасан төхөөрөмж зүүж ажиллах боломжтой.	70	Ширхэг	0	0.13
14	Цацрагийн хамгаалалтын хувцас	Цацрагийн ослын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүнийг цацрагийн тун авахаас хамгаалдаг, 1-2 мм хар-тугалган хамгаалалт бүхий иж бүрэн хувцас	24	Ширхэг	0	0.03
15	Зөөврийн шүршүүр	Хийлдэг хүрээтэй, зөөврийн авсаархан, ослын голомтод ажилласан алба хаагчдыг ариутгах халдваргүйтгэх, нэмэлтээр гар шүршүүр холбох боломжтой	24	Ширхэг	0.02	0.36
16	Шингэн сорох насос	Асгарсан бохирдол, шингэн уусмалыг соруулах	24	Ширхэг	0	0.05
Нийт			474			3.37
Нэгдсэн дүн			1,609			64.1

№	Арга хэмжээний нэр	Нийт үнэ (сая ам.дол)
1	Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангиуд, иргэд, сайн дурын хэсгүүдийн сургалт	2.97
2	Мэргэжлийн ангиуд болон сайн дурын хэсгүүдийн хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгсэл	

Дөрөв. Төслийн хүрээнд хийгдэх ажил, үр дүн

Төслийн зорилго: Монгол Улсын онцгой байдлын байгууллагын гал түймэр, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг сайжруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлж, гамшиг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэхэд оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах 3 зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг үндэсний стандартын шаардлагад хүргэн нэмэгдүүлж, олон улсын стандартад нийцсэн техник хэрэгсэл нэвтрүүлж онцгой байдлын байгууллагын гал түймэртэй тэмцэх чадавхыг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2. Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд ашиглах техник хэрэгсэл, тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн хангалтыг стандартын шаардлагад хүргэн нэмэгдүүлж, онцгой байдлын

байгууллагын эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааны чадавхыг сайжруулна.

3.Орон нутгийн удирдлага, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, иргэд, сайн дурын хэсгүүдийг сургаж бэлтгэн, шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангаж, олон нийтийн гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулна.

Төслийн хэрэгжих хугацаа: 2026-2031 он

Төслийн хэрэгжих байршил: Онцгой байдлын ерөнхий газар.

Төслийн үр дүн:

1.Ой, хээрийн гал түймэр унтраах зориулалтын автомашин, техник, багаж хэрэгслийн хүчин чадал сайжирч, ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Эрэн хайх, аврах нэгжийн ой, хээрийн гал түймэр унтраах автомашины хангалт 90 хувьд хүрч, гал түймрийн голомтод цаг алдалгүй түргэн хүрч, шуурхай унтраах чадамж нэмэгдэж, гал түймрийг хохирол багатай хурдан хугацаанд унтраах, ой, хээрийн гал түймрээс иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах чадавх нэмэгдэнэ.

2.Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжийн эрэн хайх, аврах ажиллагааны тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хүн нэг бүрийн хамгаалах хувцас хэрэгслийн хангалт сайжирч, аврагчдын үүрэг гүйцэтгэх чадавх нэмэгдэнэ.

3.Уснаас эрэн хайх, аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийн хангалт нэмэгдэж, уснаас эрэн хайх, аврах ажиллагааны хугацаа богиносож, хүний амь нас аврах боломж нэмэгдэж, усчин аврагчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны түвшин дээшилж, амь нас, эрүүл мэндэд учирч болох эрсдэл, осол, гэмтэл буурна.

4.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн осол, хими, цацрагийн аюултай бодис, материалаас үүдэлтэй осол болон уул уурхайн ослын голомтод үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн хангалт сайжирч, ослын хор уршгийг шуурхай арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг богино хугацаанд зохион байгуулах чадавх нэмэгдэж, ослын голомтод үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл хангагдана.

5.Гамшгийн дараа хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд ашиглах машин, механизм, тоног төхөөрөмжтэй болж, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг богино хугацаанд шуурхай зохион байгуулах чадавх бүрдэнэ.

6.Орон нутгийн удирдлага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурынхныг сургаж бэлтгэснээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд тэдний оролцоо нэмэгдэх, орон нутгийн гамшгаас хамгаалах бэлэн байдал сайжрах, орон нутгийн гамшгийн сөрөн тэсвэрлэх чадавх нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.


“МОНГОЛ УЛСЫН ГАМШГИЙГ СӨРӨН ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Монгол орны нутаг дэвсгэрт үер, зуд, салхи шуурга, ой, хээрийн түймэр зэрэг байгалийн аюулын давтамж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр нэмэгдэхээс гадна олон улсын хөл хориотой хүн, малын гоц халдварт өвчний шинэ төрлийн аюулууд тохиолдож, улс орны нийгэм, эдийн засагт сөргөөр нөлөөлж байна.

Улс орны дотоод, гадаадад үүссэн орчин нөхцөлөөс болж гамшгийн эрсдэл улам бүр нэмэгдэж, илүү нарийн төвөгтэй, нийлмэл шинж чанартай, олон хэмжээст болж байгаа нь онцгой байдлын байгууллагын чадавхыг шинэ шатанд гаргах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

2005-2014 онд жилд дунджаар 3,362 аюулт үзэгдэл осол тохиолдож, 214 хүн амь насаа алдаж байсан бол 2015-2024 онд жилд дунджаар 4,550 аюулт үзэгдэл, осол тохиолдож, “КОВИД-19” цар тахлаас бусад аюулт үзэгдэл ослоор 251 хүн амь насаа алдаж байгаа нь аюулт үзэгдэл ослын тохиолдлын тоог 35.3 хувь, амь насаа алдсан хүний тоог 16.8 хувиар тус тус өссөн байгааг харуулж байна. Үүнээс үзэхэд дараагийн 10 жилд энэ өсөлтөөр тооцвол 2025-2034 онд жилд дунджаар 6,156 гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдож, 293 хүн амь насаа алдах магадлалтай гэж үзэж болохоор байна.



Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас сүүлийн 80 жилд мэдэгдэхүйц дулаарч, гадаргын температур 2.4°C-аар ихсэн, хүйтэн өдрийн тоо цөөрч, халуун өдрийн тоо нэмэгдэн, хуурайших хандлага давамгайлж байна. Ингэснээр ургамлын ургалтын хугацааны хур тунадас буурч, аадар борооны хувь хэмжээ нэмэгдэж байгаагаас нийт

нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн. Цаашид Монгол орны уур амьсгал дэлхийн дундажтай харьцуулбал ихээхэн эрчимтэй өөрчлөгдөж хуурайших, цаг агаарын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлийн эрчим, давтамж нэмэгдэхээр байна.

Монгол орны нутаг дэвсгэр Төв Азийн газар хөдлөлтийн идэвхтэй бүс нутагт оршдог бөгөөд XX зуунд 8.0 магнитудын газар хөдлөлт 4 удаа, 7.0 магнитудын хүчтэй газар хөдлөлт 20 орчим удаа болж байсан. Сүүлийн жилүүдэд улсын хүн амын хагас нь амьдардаг Улаанбаатар хот орчмын бүс нутагт тохиолдох газар хөдлөлтийн идэвхжилт эрчимтэй өсөж байна. Тухайлбал, 2001-2010 онд магнитуд нь 3,0 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 50 удаа тохиолдож байсан бол 2011-2022 оны хувьд 72 удаа болж нэмэгдсэн. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка)-аас 2013 онд Улаанбаатар хотын хэмжээнд хийсэн газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээгээр хот орчмын идэвхтэй хагарлууд дээр 6.6-7.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт болоход хотын нийт барилгажсан хэсгийн 30 хувь нурж, ойролцоогоор 40-60 мянган иргэд өртөж амь нас, эрүүл мэндээрээ хохирох тооцоог гаргасан.

Онцгой байдлын байгууллагын хүч хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн хангалтад “Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавих шаардлага” MNS 6412:2013 стандартыг мөрддөг. Энэхүү шаардлагын дагуу 9 төрлийн 501 автомашин байхаас 7 төрлийн 305 автомашин буюу 62.1 хувьтай байна.

“Эрэн хайх, аврах нэгжид тавих шаардлага MNS 6740:2018” стандартаас хүний нөөцийн хангалт 53.2 хувь, техник хэрэгслийн хангалт 61.3 хувьтай байна. Стандартын дагуу Монгол Улсын хэмжээнд нийт 66 эрэн хайх, аврах нэгж байх шаардлагатайгаас одоогийн байдлаар 42 нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид 24 эрэн хайх аврах нэгж шинээр байгуулах шаардлагатай.

Уснаас аврах ажиллагааны хүн нэг бүрийн хамгаалах хувцас стандартаар 248 байхаас бэлэн байгаа нь 68 бөгөөд цаашид 180 ширхэг шаардлагатай. Мөн уснаас аврах ажиллагаанд ашиглагдах 45 нэр төрлийн 1152 багаж хэрэгсэл, техник байхаас бэлэн байгаа 682 бөгөөд цаашид 470 ширхэг нэн шаардлагатай байна. Техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийн хангалт 2024 оны байдлаар 48.6 хувьтай байна.

Цацраг, химийн хүн нэг бүрийн хамгаалах хувцас стандартаар 124 байхаас бэлэн байгаа 36, цаашид 88 ширхэг шаардлагатай. Мөн цацраг химийн аврах ажиллагаанд ашиглагдах 50 нэр төрлийн 657 багаж хэрэгсэл байхаас бэлэн байгаа нь 311, цаашид нөхөн хангалтаар 346 багаж хэрэгсэл шаардлагатай байна. Хими, цацрагийн багаж, тоног төхөөрөмж 2024 оны байдлаар 17.7 хувьтай байна.

Уул уурхайн аврах ажиллагаанд ашиглагдах хүн нэг бүрийн хувцас хэрэглэл стандартаар 32 байхаас бэлэн байгаа 21, нөхөн хангалт хийхэд 11 иж бүрдэл хувцас шаардлагатай. Мөн уул уурхайн аврах ажиллагаанд ашиглагддаг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж 33 нэр төрлийн нийт 3427 байхаас бэлэн байгаа нь 1600, нөхөн хангалт хийхэд 1827 шаардлагатай байна. Уул уурхай, аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийн хангалт 2024 оны байдлаар 42 хувьтай байна.

Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэлтэй холбоотой ослын үед ашиглах багаж, хувцас хэрэгслийн хангалт 2024 оны байдлаар 18.4 хувьтай байна.

Орон нутгийн удирдлага, иргэд, олон нийтийн гамшгаас хамгаалах чадавх 2024 оны байдлаар 51 хувьтай байна.

2.Төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүн, ач холбогдол

-Ой, хээрийн гал түймэр унтраах зориулалтын автомашин, техник, багаж хэрэгслийн хүчин чадал сайжирч, ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Эрэн хайх, аврах нэгжийн ой, хээрийн гал түймэр унтраах автомашины хангалт 90 хувьд хүрч, гал түймрийн голомтод цаг алдалгүй түргэн хүрч, шуурхай унтраах чадамж нэмэгдэж, гал түймрийг хохирол багатай хурдан хугацаанд унтраах, ой, хээрийн гал түймрээс иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах чадавх нэмэгдэнэ.

-Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжийн эрэн хайх, аврах ажиллагааны тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хүн нэг бүрийн хамгаалах хувцас, хэрэгслийн хангалт сайжирч, аврагчдын үүрэг гүйцэтгэх чадавх нэмэгдэнэ.

-Уснаас эрэн хайх, аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийн хангалт нэмэгдэж, уснаас эрэн хайх, аврах ажиллагааны хугацаа богиносж, хүний амь нас аврах боломж нэмэгдэж, усчин аврагчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны түвшин дээшилж, амь нас, эрүүл мэндэд учирч болох эрсдэл, осол, гэмтэл буурна.

-Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн осол, хими, цацрагийн аюултай бодис, материалаас үүдэлтэй осол болон уул уурхайн ослын голомтод үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн хангалт сайжирч, ослын хор уршгийг шуурхай арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг богино хугацаанд зохион байгуулах чадавх нэмэгдэж, ослын голомтод үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл хангагдана.

-Гамшгийн дараа хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд ашиглах машин, механизм, тоног төхөөрөмжтэй болж, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг богино хугацаанд шуурхай зохион байгуулах чадавх бүрдэнэ.

-Орон нутгийн удирдлага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурынхныг сургаж бэлтгэснээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд тэдний оролцоо нэмэгдэх, орон нутгийн гамшгаас хамгаалах бэлэн байдал сайжрах, орон нутгийн гамшгийн сөрөн тэсвэрлэх чадавх нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

Төсөл хэрэгжсэнээр хүрэх үр дүн

№	Нэр төрөл	Суурь түвшин /2024 он/	Төсөл хэрэгжсэнээр
1	Гал унтраах автомашин	62.1%	82.1%
2	Гал түймэр унтраах аврах ажиллагааны багаж хэрэгсэл	57.0%	78.3%

3	Эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааны чадавхыг сайжруулах техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгсэл	61.3%	85.3%
4	Уснаас эрэн хайх, аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгсэл	48.6%	82.1%
5	Хими, цацрагийн багаж, тоног төхөөрөмж	17.7%	66.2%
6	Уул уурхайн аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгсэл,	42.0%	77.7%
7	Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэлтэй холбоотой ослын үед ашиглах багаж, хувцас хэрэгсэл/	18.4%	57.6%
8	Орон нутгийн удирдлага, иргэд олон нийтийн гамшгаас хамгаалах чадавх	51.0%	68.0%

3.Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Тус төсөл нь Улсын төсвөөр бүрэн хангагдах боломжгүй объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах, төрөл бүрийн гамшгаас эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, нийт хүн амын аюулгүй байдлыг хангах, нэн ялангуяа ядуурал болон нийгэм-эдийн засгийн бусад хүчин зүйлээс шалтгаалж байгалийн болон хүний гаралтай аюулт үзэгдэлд өртөх өндөр эрсдэлтэй эмзэг бүлгийн хүн амыг хамгаалахад чиглэсэн хөрөнгө оруулалт болно.

Олон улсад сөрөн тэсвэрлэх чадавх, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бэлтгэл, бэлэн байдалд зарцуулсан хөрөнгө оруулалт, гамшгийн үед болон хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө оруулалтаас хэд дахин бага, үр ашигтай хөрөнгө оруулалт байдгийг олон судалгаагаар нотолсон бөгөөд гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оруулах хөрөнгө оруулалтыг илүүтэйгээр чухалчилж авч үздэг байна.

<i>Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хөрөнгө оруулалт, гамшгийн үеийн хор уршгийг арилгах үйл ажиллагааны зардлын хэмжээ (судалгааны тайлангуудаас)</i>		
Гамшгийн эрсдэлийг бууруулах, нөхөн сэргээх дэлхийн сан:	АНУ-ын Худалдааны танхимын тайланд:	АНУ-ын Онцгой байдлын байгууллагын судалгаанд:
Гамшгийн эрсдэлийг бууруулахад зарцуулсан 1 доллар бүр ирээдүйд гамшгаас үүдэлтэй хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд зарцуулагдах 15 доллартой тэнцэнэ. (file:///C:/Users/User/Downloads/UNDRR-GAR2025-web-revised.pdf)	Сөрөн тэсвэрлэх чадавх болон бэлтгэл, бэлэн байдалд зарцуулсан 1 ам.доллар гамшгийн үеийн хохиролд зарцуулах байсан 13 ам.доллартой тэнцэнэ. (https://www.uschamber.com/assets/documents/USCC_2024_AlIstate_Climate_Resiliency_Report.pdf)	Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан 1 ам.доллар тутамд гамшгийн үед зарцуулах байсан 4 ам.долларыг хэмнэдэг. (https://www.wbdg.org/files/pdfs/MS2_2017Interim%20Report.pdf)

Байгалийн гамшиг, аюулт үзэгдэлд өртөж, амь нас, эрүүл мэнд, эдийн засгаар хохирч буй иргэдийн дийлэнх хувийг амьжиргааны түвшин доогуур, эмзэг бүлгийнхэн, хүүхэд, эмэгтэйчүүд, малчид эзэлдэг. Тус төслийг хэрэгжүүлснээр нийгэм, байгаль орчин, хөдөө аж ахуй, дэд бүтцийн салбарт гамшгийн улмаас учрах эрсдэл, хохирлыг бууруулах боломжтой болох бөгөөд гамшгийн олон аюулыг бууруулах хувийг тус бүрд нь тооцож гаргасныг хүснэгтээр үзүүлэв.

Гамшгийн хохирлыг бууруулах урьдчилсан төсөөлөл

№	Үзүүлэлт	Бууралт %
1	Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос шалтгаалсан нас баралт	10.4
2	Зудын хохирол	11.8
3	Ой, хээрийн гал түймрийн хохирол	13.4
4	Үер усны аюул ослын хохирол	13.5
5	Цацраг, химийн ослын хохирол	12.9
6	Объектын гал түймрийн хохирол	14.2
Дунджаар		12.7

- Гамшиг, ослын голомтод дуудлагаар шуурхай хүрч ажиллаж, нэрвэгдсэн иргэдийг эмнэлгийн байгууллагад цаг алдалгүй хүргэж, амь насыг авран хамгаална.

- Дэвшилтэт шинэ техник, тоног төхөөрөмжийг өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр засвар үйлчилгээ бага шаардах тул урсгал зардлын хэмнэлтийг хийнэ.

- Гамшиг, ослоос шалтгаалан инженерийн дэд бүтцийн байгууламжуудын хэвийн ажиллагаа алдагдсан нөхцөлд яаралтай сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай хэрэгжүүлэх чадавх дээшилснээр гамшгийн үеийн эдийн засгийн алдагдлыг бууруулах, сэргээн босгох үйл ажиллагааг цаг алдалгүй зохион байгуулах, гамшгийн улмаас үүсэх зардлыг бууруулна.

- Гал түймрээс ойн болон бэлчээрийн санг хамгаалж, цөлжилтийг бууруулахад хувь нэмэр оруулснаар "Тэрбум мод үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх, экологийн тэнцвэртэй байдлын хангахад шууд бусаар үнэтэй хувь нэмэр оруулна.

- Иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, мал амьтанд учирч болох хохирлыг бууруулах төдийгүй улсын хэмжээнд гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлж Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлнэ.